



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2021 • № 56



Б.ЛХАГВАСҮРЭН: **БАНКНЫ
САЛБАР НЬ ӨӨРЧЛӨЛТ,
ШИНЭЧЛЭЛД
МАНЛАЙЛЖ ИРЛЭЭ**

**ХӨГЖИЛД
ТЭМҮҮЛСЭН ОН
ЖИЛҮҮД**

ЭНДЭГШЛЭХ ХЭРЭГТЭЭНД
ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГТЭЭНД



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

МОНГОЛ УЛСАД 2 ШАТЛАЛТ БАНКНЫ ТОГТОЛЦОО ҮҮСЭЖ ХӨГЖСӨНИЙ 30 ЖИЛИЙН ОЙН

БАЯРЫН МЭНДЧИЛГЭЭ



Монгол Улсад орчин цагийн банк, санхүүгийн систем үүсэж хөгжсөний 97 жилийн ой, 2 шатлалт банкны тогтолцоо үүсэж хөгжсөний 30 жилийн ойг тохиолдуулан системийн үе үеийн ажилтан, албан хаагч болон харилцагч Та бүхэнд "Банкны ажилтны өдөр"-ийн мэндийг дэвшүүлье!

Энэ өдөр бол санхүүгийн системийн хөгжлийн түүхийг босголцсон, үүнд хувь нэмрээ оруулж буй хүн бүрийн хувьд амжилтаа дүгнэж, ирээдүйн зорилго өөд нэг алхам урагшлах тэмдэглэлт өдөр билээ. 2021 онд Монгол Улсад 2 шатлалт банкны тогтолцоо үүсэж хөгжсөний 30 жилийн ой тохиосон онцлогтой жил болж байна. Энэ түүхэн хугацаанд банкны салбарын хувьд хүний нөөцийн чадавхи, хууль эрх зүйн зүйн орчин, зохицуулалт, техник технологийн нэвтрүүлэлт, бүтээгдэхүүн үйлчилгээ зэрэг бүх чиглэлээр тасралтгүй хөгжин шинэчлэгдэж ирлээ. Энэ онд Банкны тухай хууль шинэчлэгдсэнээр арилжааны банкууд олон улсын нийтлэг жишигт нийцсэн засаглал, өмчлөлийн хэлбэрт шилжих, нээлттэй ил тод, олон нийтийн хяналттай болох реформ хэрэгжиж эхэллээ. Энэ нь зохицуулагч байгууллага, банк, банкны харилцагч, хөрөнгө оруулагчдын хувьд цоо шинэ эрин үеийн эхлэл юм.

Монголбанкны хувьд дэлхий нийтийг хамарсан цар тахлын энэ үед банкны салбарын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хадгалах, санхүүжилтийн нөхцөлийг таатай байлгах замаар нийгэм, эдийн засаг дахь сөрөг нөлөөг зөөлрүүлэхэд чиглэсэн бодлогын цогц арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлж байна. Түүхэн сорилттой зэрэгцэж түүхэн боломж бий болдог жишгээр энэ цаг үе бидэнд эдийн засаг, санхүүгийн системдээ суурь реформ хийж эхэллээ. Төрөлжсөн бөгөөд ногоон эдийн засгийн суурийг тавих, дижитал шилжилт хийх, ирээдүйн инновацийн төслүүдийг хэрэгжүүлэхэд банк, санхүүгийн системийн оролцоо, манлайлал зайлшгүй чухал байна. Иймд илүү дархлаатай, байгаль орчинд ээлтэй, бүтээмж өндөртэй эдийн засгийг бүтээлцэх нь банкны салбарын дараагийн 30 жилийн том сорилт боллоо. Энэхүү сорилтыг боломж болгож, хөгжлийг бид хамтдаа бүтээж чадна гэдэгт итгэл төгс байна.

Монголбанк эдийн засагт гарч буй эерэг өөрчлөлтийг бататгах, банкны салбарыг эрүүл, найдвартай байдлыг хангах, нээлттэй, ил тод, хариуцлагатай байх зарчмыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, эдийн засгийн тогтвортой байдал, ирээдүйн өсөлт хөгжлийн чухал тулгуур болсон реформ, шинэчлэлийг цаашид эрчимжүүлэхэд илүүтэй анхаарах болно.

Монгол Улсад 2 шатлалт банкны салбар үүсэж хөгжсөн 30 жилийн түүхийг бүтээлцсэн үе үеийн банкирууд, санхүүгийн салбарын хамт олондоо ажлын өндөр амжилт, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсье!

**БАНК, САНХҮҮГИЙН САЛБАР УЛАМ БҮР ХҮЧИРХЭГЖИН, ХӨГЖИЖ,
УЛС ОРНЫ ХӨГЖЛИЙН ЗАМ ДАРДАН БАЙХ БОЛТУГАЙ!**

**МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ
Б.ЛХАГВАСҮРЭН**



04

ОНЦЛОХ МЭДЭЭ

ГЭРЭЭНД ГАРЫН ҮСЭГ
ЗУРАХ ЁСЛОЛ БОЛЛОО



12

**ТҮҮХИЙН
ХУУДАСНАА**

БНМАУ-ЫН
БАНКНЫ ХУУЛЬ



26

**МОНГОЛБАНКНЫ
МЭДЭЭЛЭЛ**

ОН ГАРСНААС ХОЙШ
4162 ИРГЭНД 307.6
ТЭРБУМ
ТӨГРӨГИЙН
ИПОТЕКИЙН ЗЭЭЛ
ОЛГОВ



34

БАНКИР

ХОЁР ШАТЛАЛТ БАНКНЫ
СИСТЕМИЙН ХӨГЖИЛ



07

ЯРИЛЦЛАГА

Б.ЛХАГВАСҮРЭН:
БАНКНЫ САЛБАР НЬ
ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛД
МАНЛАЙЛЖ ИРЛЭЭ



16

**ДУРСАМЖ, БАЙР
СУУРЬ**

ХӨГЖИЛД
ТЭМҮҮЛСЭН ОН
ЖИЛУУД

29

**МӨНГӨ УГААХ,
ТЕРРОРИЗМЫГ
САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ
ТЭМЦЭХ**

МӨНГӨ УГААХ,
ТЕРРОРИЗМЫГ
САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ
ТЭМЦЭХ
ТОГТОЛЦООНД
ЭРСДЭЛИЙН
ҮНЭЛГЭЭГ ХИЙЖ
БАЙНА



39

**САНХҮҮГИЙН
БОЛОВСРОЛ**

ТӨВ БАНК,
АРИЛЖААНЫ
БАНКНЫ ЯЛГАА

○ ГЭРЭЭНД ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ ЁСЛОЛ БОЛОО



Монголбанкнаас “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг 2016 оноос эхлэн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөрийн хэрэгжилтийг үр дүнтэй хангах хүрээнд Монголбанк, Шпаркасс банкны сангийн хооронд санхүүгийн боловсролыг дэмжих санаачилгыг хэрэгжүүлэх, орон нутаг болон алслагдмал бүс нутагт амьдарч буй иргэдэд сургалт зохион байгуулах үйл ажиллагаанд зориулан автобус болон сургалтын хэрэглэгдэхүүнүүд бэлэглэх гэрээнд гарын үсэг зурах ёслол боллоо. Энэхүү гэрээ байгуулах үйл ажиллагаа “Дэлхийн мөнгөний долоо хоног” аяны үеэр тохиож байгаагаар онцлог юм. Бэлэглэлийн гэрээнд гарын үсэг зурах ёслолд ХБНГУ-ын Элчин сайдын яам - Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Ёорн Розенберг оролцсоны зэрэгцээ Монголбанкныг төлөөлж Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Г.Энхтайван, ХБНГУ-ыг төлөөлж Шпаркасс банкны Монгол дахь сангийн суурин төлөөлөгч Маркус Лох нар гарын үсэг зурлаа.

○ ЗЭЭЛИЙГ ЗОРИУЛАЛТЫН БУСААР АШИГЛАВАЛ ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛҮҮЛНЭ



Монголбанк нь банк, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангаж эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 42 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-г хамтран хэрэгжүүлж байна. Эдийн засгийг сэргээх, ажлын байрыг хадгалахад чухал үүрэгтэй үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхлэгчийн үйл ажиллагааг эргэлтийн хөрөнгө, зээлийн дахин санхүүжилтийн эх үүсвэрээр дэмжих зорилготой тус хөнгөлөлттэй санхүүжилтийн ашиглалт, зарцуулалтад тавих хяналт, тайлагналын тогтолцоог банкны дотоод хяналт, Сангийн яам, Монголбанкны хамтарсан шалгалт болон хууль сахиулах эрх бүхий байгууллагын оролцоотойгоор бүрдүүлж байна. Тухайлбал, “Ажлын байрыг дэмжих зээл”-ийг зориулалт бусаар ашиглах, ашиг сонирхлын зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, зээлдэгч болон зээл олгож байгаа банкны үйл ажиллагаанд хянах зорилгоор Ажлын байрыг дэмжих зээлийн санхүүжилтийн ерөнхий гэрээг банкуудтай байгуулснаас гадна 2021 оны 3 дугаар сарын 19-ний өдөр Сангийн яам, Монголбанк хамтран “Ажлын байрыг дэмжих зээлийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих журам”-ыг батлан хэрэгжүүлж эхлээд байна. “Ажлын байрыг дэмжих зээл”-ийг зориулалт бусаар ашиглаж зөрчил гаргасан тохиолдолд зээлийн хүүгийн дэмжлэгийг цуцлах, хүүгийн дэмжлэггүй зээлд шилжүүлэн, зээлийг нэн даруй буцаан төлүүлэх, төрд учруулсан хохирлыг шаардах бөгөөд холбогдох хууль сахиулах эрх бүхий байгууллагаар шалгуулж, хуульд заасан хариуцлага хүлээлгэх болно.

○ ТӨЛБӨРИЙН КАРТЫН СИСТЕМИЙГ БҮРЭН ШИНЭЧИЛЛЭЭ



Монголбанкнаас Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Төлбөрийн системийн шинэчлэл төсөл”-ийн хүрээнд Төлбөрийн картын системийг 2021 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр бүрэн шинэчлэх ажлыг гүйцэтгэж, шинэ системийг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүллээ.

Энэ нь Англи улсын “TranzWare” систем бөгөөд шинэ төрлийн гүйлгээг дэмжих, системийн нууцлал аюулгүй байдал, системийн ачаалал, хүчин чадлыг бүрэн хангах зэрэг олон улсын стандартыг хангасан цогц систем юм. Тус системийг нэвтрүүлснээр банкууд болон оролцогчид хөрөнгийн удирдлага буюу нөөцийн зохицуулалтыг хэрэгжүүлж эхэлж байна.

Хамтран ажилласан банкууд болон финтек байгууллагуудад талархал илэрхийлье.

РЕПО АРИЛЖААГААР БАНКУУДАД 275 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН САНХҮҮЖИЛТ ОЛГОЛОО



Мөнгөний бодлогын хорооны 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу Монголбанк 2021 оны 2 дугаар улирлын ээлжит репо арилжааг 2021 оны 5 дугаар сарын 17-ны өдөр зохион байгууллаа. Төв банкнаас 350 тэрбум хүртэл төгрөгийн репо арилжаа зарлаж, 6 банкнаас нийт 275 тэрбум төгрөгийн репо санхүүжилт авах санал ирүүлснийг Монголбанк бүрэн биелүүллээ.

Уг санхүүжилтээр банкууд 1) жижиг, дунд үйлдвэрлэл, 2) уул уурхайн бус экспорт, 3) үйлчилгээ, 4) боловсруулах үйлдвэрлэл, 5) хоёр зуу болон түүнээс дээш ажилтантай бөөний болон жижиглэн худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж буй этгээдэд зээл олгох юм.


Репо санхүүжилтийн зээлийг Хаан, Худалдаа хөгжлийн, Голомт, Төрийн, Хас, Капитрон, Тээвэр хөгжлийн, Кредит, Богд банканд хандаж авах боломжтой.

ФИТЧ АГЕНТЛАГ МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙН ҮНЭЛГЭЭГ "В", ТӨЛӨВИЙГ "ТОГТВОРТОЙ" ХЭВЭЭР ҮЛДЭЭСНИЙГ БАТАЛГААЖУУЛЛАА



Фитч агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг "В", төлөвийг "Тогтвортой" хэвээр үлдээснээ 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдөр зарлалаа. Тус агентлаг нь Монгол Улсын эдийн засгийг 2021 онд 5.0 хувьд хүрч сэргэх төлөвтэй байгааг онцолсон байна. Цаашид Монгол Улсын вакцинжуулалт, хөл хориог үе шаттайгаар сулруулж байгаа байдал, өрх болон бизнесийн байгууллагуудад зориулсан санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээнүүд зэргээс шалтгаалан дотоодын бизнесийн үйл ажиллагаа ирэх улирлуудад сэргэх хүлээлттэй байна. Монголбанк нь 2020 онд бодлогын хүүг 5 нэгж хувиар бууруулан 6% буюу түүхэн доод хэмжээндээ хүргэж, 2021 оны эхний хагас жилийн эцэс хүртэл банкууд дахь зээлийн эргэн төлөлтийн хугацааг хойшлуулах бодлогоо сунгасан. Засгийн газраас 2 дугаар сард 10 их наяд төгрөгийн 3 жилийн хугацаатай эдийн засгийг дэмжих төлөвлөгөөг баталснаар банкууд ажил эрхлэлтийг дэмжих, ЖДҮ-ийг дэмжих, хөдөө аж ахуйн, ипотекийн хөнгөлөлттэй зээлүүдийг олгож эхэлсэн байна. Түүнчлэн төв банк нь хувийн байгууллагуудын бизнесийн сэргэлтийг дэмжих зорилгоор банкны зээлийг дахин санхүүжүүлэх репо санхүүжилтийг нэмэгдүүлсэн байна. Фитч агентлаг нь Монгол Улсын 2021 оны эдийн засгийн өсөлт болон эдийн засгийн бодлогууд нь банкны салбарын төлөв байдлыг сайжруулна гэж үзэж байна. Хэдийгээр Ковид-19-өөс шалтгаалан бүтэц өөрчилсөн зээл нь нийт зээлийн 22%-ийг эзэлж байгаа ч цаашид эдийн засгийг сэргээх хөнгөлөлттэй зээлийн төлөвлөгөө нь 2021 онд активын чанарын дарамтыг бууруулна гэж үзэв.

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ТАНИЛЦУУЛАХ ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЛОО



Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хороо хамтран Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийн цахим хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Үүгээр хуулийн төслийг холбогдох төрийн байгууллага болон санхүүгийн салбарын мэргэжлийн холбоодод танилцуулах, санал авах ажиллагааг эхлүүлж байгаа юм.

Хэлэлцүүлгийг нээж Монголбанкны Тэргүүн дэд Ерөнхийлөгч Г.Дөлгөөн үг хэлж, ажлын хэсгээс санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах олон улсын шилдэг туршлага, зөвлөмжүүд, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, тандан судалгаа, хуулийн төслийн зорилго, бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ, хуулийн төсөл батлагдсанаар үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дүнгийн талаарх илтгэлүүдийг тавилаа. Мөн шүүхийн бус журмаар санхүүгийн хэрэглэгч болон санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч хоорондын маргааныг шийдвэрлэх тогтолцоо болон олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн хэрэгжилт зэрэг сэдвээр танилцуулга хийгдэж, хэлэлцүүлгийн явцад оролцогчдын асуултад хариулж, санал солилцов.

“БАНКНЫ СИСТЕМД НӨЛӨӨ БҮХИЙ БАНК”-ИЙГ ТОГТООХ АРГАЧЛАЛЫГ ШИНЭЧЛЭВ



Банкны тухай хуульд 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.20-д заасан “Банкны системд нөлөө бүхий банк”-ыг Монголбанкнаас тогтоох зохицуулалтын хүрээнд “Банкны системд нөлөө бүхий банк”-ийг тогтоох аргачлалыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн А-104 дугаар тушаалаар, “Банкны системд нөлөө бүхий банк”-ны жагсаалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн А-105 дугаар тушаалаар баталлаа.

БАНКУУДЫН ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НӨХЦӨЛИЙГ НЭГТГЭСЭН ЦАХИМ ХУУДАС АШИГЛАЛТАД ОРЛОО



Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28 өдрийн 21 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийг хэрэгжүүлэх дэд арга хэмжээний 2.4.2.-т “Банкны санал болгож байгаа зээлийн хугацаа, хүү, шимтгэл, хураамжийг зээлийн төрөл бүрээр харьцуулсан мэдээллийг олон нийтэд тогтмол гаргаж, банкны харилцагч, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлэх” ажлын хүрээнд Монголбанк, Монголын Банкны Холбоо хамтран зээлийн бүтээгдэхүүний нөхцөлийн нэгдсэн цахим хуудсыг боловсруулж олон нийтэд зарлахад бэлэн боллоо.

Иргэд, байгууллагууд www.mongolbank.mn/loanrate цахим холбоосоор орж, бүтээгдэхүүн сонгох цэснээс өөрийн хэрэгцээнд тохирох зээлийг сонгон, банкуудын санал болгож буй зээлийн нөхцөлүүдийг түргэн хугацаанд харьцуулан харах боломжтой юм.

МОНГОЛБАНКНЫ НЭРЭМЖИТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ БОЛЛОО



Монголбанкнаас эдийн засаг, статистик, санхүүгийн чиглэлээр судалгаа шинжилгээ хийдэг судлаачид болон оюутнуудын судалгааг дэмжих, бүтээлийг нь нийтэд түгээн таниулах, бодлого боловсруулахад оролцох оролцоог нь нэмэгдүүлэх зорилгоор эрдэм шинжилгээний бага хурал жил бүр зохион байгуулж ирсэн билээ. Энэ жил оюутны ангилалд 38 бүтээл, судлаачийн ангилалд 20 бүтээл ирснээс хоёрдугаар шатны шалгаруулалтад тус бүр 5 бүтээл шалгарч, (2021.05.31) эцсийн хэлэлцүүлгийг цахимаар хийв.

Эцсийн шатанд шинэлэг санаа, асуудал дэвшүүлсэн байдал, судалгааны арга зүй, ач холбогдол зэргийг харгалзан үзэж ангилал тус бүрт эхний гурван байрыг тодрууллаа. Энэ удаагийн хурал нь Монгол Улсад хоёр шатлалт банкны тогтолцоо үүсэж хөгжсөний 30 жилийн ойтой давхцаж байгаагаараа онцлог байв.

Ийнхүү оюутны ангилалд шилдгээр шалгарсан бүтээлүүдийг танилцуулж байна.

Тэргүүн байр: Х.Мөнхжин (СЭЗИС) – “Эдийн засгийн тодорхой бус байдал”

Дэд байр: Э.Саруулбуян, С.Мөнхням (МУИС) – “Валютын ханшид нөлөөлөх сүргийн зан төлөвийг шинжлэх нь”

Гутгаар байр: О.Номин-Эрдэнэ (СЭЗИС) – “Мөнгөний болон Макро зохистой бодлого, түүний макро эдийн засгийн үр нөлөөг шинжлэх нь”

Харин судлаачийн ангилалд дараах бүтээлүүд шалгарлаа:

Тэргүүн байр: Ч.Алтан-Өлзий, М.Лхагвадорж – “Хөвөгч коэффициенттэй регресс ашиглан инфляцын таамаглал хийх нь”

Дэд байр: Б.Билэгт, Б.Гэрэлмаа – “Монгол Улсын төсвийн үржүүлэгчийн тооцоо: TV-SVAR загвар”

Гутгаар байр: Г.Баттулга – “Dividend Jump Decision of a Company - Stochastic DDM”.



■ Б.ЛХАГВАСҮРЭН: БАНКНЫ САЛБАР НЬ ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛД МАНЛАЙЛЖ ИРЛЭЭ

Монгол Улсад хоёр шатлалт банкны тогтолцоо бий болсны 30 жилийн ойн хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэнтэй банкны салбарын хөгжил, цаашдын төлөв, цар тахлын хямралын үед авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар дэлгэрэнгүй ярилцлаа.

Манай улс зах зээлийн нийгэмд шилжихтэй зэрэгцээд хоёр шатлалт банкны тогтолцоо цоо шинээр бий болсон бөгөөд өдгөө 30 дахь жилийнхээ нүүрийг үзэж байна. Тухайн үед гарсан энэ шийдвэрийн ач холбогдол, үр дүнг та юу гэж тодорхойлох вэ?

Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээл хөгжсөн ардчилсан тогтолцоог бий болгоод 30 гаруй жил болж байна. Энэ хүрээнд

улс төр, нийгэм, эдийн засгийн томоохон өөрчлөлтүүд гарсны нэг нь банкны тогтолцооны шинэчлэл юм. Улсын банк гэх нэг системээс хоёр шатлалтай буюу бодлого зохицуулалтыг нь хийдэг төв банк, бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ санхүүгийн зуучлал үзүүлдэг арилжааны банктай тогтолцоо бий болсон билээ.

Өнөөдрийн өндөрлөгт хүрэхэд шулуун дардан байгаагүй, банкны салбар тодорхой хэмжээний эрсдэл, хүндрэл,

бэрхшээлтэй тулж байв. Зөвхөн дотоод эдийн засгийн асуудлаас гадна бүс нутгийн хэмжээний, бүр дэлхийг цочроосон хүндрэл, хямралыг хамт л туулж, давж гарч өнөөдрийг хүрээд байна.

Өнгөрсөн хугацаанд дотоодын банкны салбар өөрчлөлт, шинэчлэл, дэвшилд манлайлж, түүчээлж оролцож ирсэн гэж би боддог. Нийт санхүүгийн салбарын 90 гаруй хувийг банкны салбар бүрдүүлж байгаа нь үүнийг нотолно. Энэ нь мөн банкны салбар хэрхэн

хүчирхэгжиж, өнөөдрийн өндөрлөгт хүрснийг харуулж байна. Банкны салбар дангаар хүчирхэгжээд зогсохгүй бусад салбар, тэр дундаа томоохон ААН-үүд ихэнхдээ банкны зээл, үйлчилгээг авч, хамтдаа өсөж хөгжжээ. Эргээд харахад цөөнгүй арилжааны банк татан буугдсан ч өнөөдрийг хүртэл ажиллаж буй банкууд Монгол Улсын эдийн засгийг санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ дэмжсэн хэвээр байна.

Банкны салбар өнгөрсөн хугацаанд олон хямралтай нүүр тулж байв. Тухайлбал 1997 оны Азийн хямрал, 2008 оны дэлхийн санхүүгийн хямралыг нэрлэж болно. Өнөөдөр ч гэсэн Ковид-19 цар тахлаас үүдэлтэй томоохон сорилт, бэрхшээлтэй нүүр тулжээ. Гэхдээ энэ бүхнийг даван гарч, амжилттай ажиллаж байгаа нь бодлого зохицуулалт, банкуудын ур чадвар, бизнес төлөвлөгөө, нөхцөл байдалтай зөв зохицож ажиллаж байгаатай холбоотой гэж бодож байна.

Дэлхийн хэмжээний томоохон хямралуудтай тулгарах бүртээ төв банк туршлагаждаг. Сүүлийн үед Ковид-19-өөс үүдсэн хүндрэл томоохон сорилт боллоо. Үүний эсрэг хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээний үр дүнд эхний улиралд эдийн засаг 15.7% өсөөд байна. Төв банкнаас хямралын үед авч хэрэгжүүлсэн бодлого, шийдвэрийн талаар илүү

дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү?

Төв банкны тухай хуулиар Монголбанк үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилттой ажилладаг. Ковид-19-ийн тохиолдол 2020 оны нэгдүгээр сард анх бүртгэгдсэнээс хойш хорио цээрийн дэглэм өнөөдрийг хүртэл үргэлжилж байна. Үүнтэй холбоотой дэлхийн эдийн засаг агшсан бөгөөд Монголын эдийн засаг ч үүнийг тойрсонгүй 5.3 хувь агшлаа.

Төв банк цар тахлын үед ямар арга хэмжээ авч хэрэгжүүлбэл эрсдэлийг хохирол багатай давж, хурдан сэргээж, тогтворжуулах вэ гэдэг тал дээр богино, дунд, урт хугацааны төлөвлөгөө гаргаж ажиллаж байна. Авсан голлох арга хэмжээнүүдээс дурдвал төв банкны үнэт цаасны хүү буюу бодлогын хүүг цар тахал гарснаас хойш нийтдээ 5 нэгжээр буулгаж түүхэн доод хэмжээ 6 хувьд хүргэлээ. Өөрөөр хэлбэл Мөнгөний бодлогын төлөвийг зөөллөж, мөчлөг сөрөх бодлого хэрэгжүүлж байна. Эдийн засаг царцаж, агшсан үед бэлэн мөнгөний хомсдол бий болдог. Үүнийг бууруулах, шинэ эх үүсвэр, санхүүжилтээр хангах үүднээс мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх бодлого барьсан нь энэ юм. Мөн

эдийн засгийн идэвх сулармагц аж ахуйн нэгжүүд бэлэн мөнгө, санхүүжилтээр дутагдаж эхэлдэг. Үүнийг найдвартай хангах үүднээс хуримтлагдсан байсан эх үүсвэрүүдийг түлхүү гаргах арга хэмжээ авч, заавал байлгах нөөц зэрэг мөнгөний бодлогын арга хэрэгслийг мөн зөөлрүүлээ.

Дараагийн арга хэмжээ санхүүгийн тогтвортой байдалд чиглэж байна. Мэдээж эдийн засаг царцаад, ААН-ийн үйл ажиллагаа доголдохоор зээл төлөлт багасдаг. Тэгэхээр иргэд, ААН-д очсон дарамтыг багасгах үүднээс зээлийн хугацаа, хүү төлөлт, үндсэн өр төлөлтийн хугацааг сунгах, заримыг нь чөлөөлөх арга хэмжээ авлаа. Мөн банкуудад очдог дарамтыг бууруулах зорилгоор төв банкнаас явуулдаг зохистой харьцааны үзүүлэлтүүдийг суллах, тодорхой хугацаанд үйлчлэлийг нь түдгэлзүүлэх, царцаах арга хэмжээ авсан юм. 2020 оны турш эдгээр арга хэмжээг үе шаттай явуулсны үр дүнд 2021 оны нэгдүгээр улирлын байдлаар сүүлийн хэдэн жилд байгаагүй өсөлт гарсан буюу ДНБ 15.7 хувиар нэмэгджээ. Гэхдээ өнгөрсөн онд цар тахлын улмаас эдийн засаг огцом агшсан тул алдсан үзүүлэлтээ нөхөж, эргэн сэргэж байна гэж ойлгох нь зүйтэй. Одоо төв банкны бодлого, өнөөдрийн хийж буй үйл ажиллагааны зорилт энэ амжилтаа бататгаж, цаашид илүү сайжруулахад чиглэж байна.

Төв банкнаас мөн Засгийн газрын хөтөлбөрийг дэмжиж оролцож байгаа. Нэг талаас эдийн засагт хүндрэлтэй зүйл байгаа ч оны эхний улиралд гадаад худалдаа сайн, төгрөгийн ханш тогтвортой байна.

Эдийн засгийн цаашдын төлөвт хөл хорионы дэглэм цуцлагдах, цар тахал хумигдах, вакцинжуулах арга хэмжээ чухал нөлөөтэй. Энэ утгаараа Засгийн газрын хэрэгжүүлж буй “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх ₮10 их наядын хөтөлбөр”-ийг төв банк дэмжиж ажиллаж байна. Энэ хүрээнд нэгэнт санхүүгийн салбарт бий болчихсон байгаа хуримтлалыг бодит эдийн засагт дэмжлэг үзүүлэх санхүүжилт болгох бодлого барьж байна. Бодлогын үр дүнд эдийн засаг сэргэж эхэлсэн гэдгийг дахин онцлох нь зүйтэй болов уу.

Экспорт нэмэгдэж, гадаад худалдаа ашигтай гарч, төгрөгийн ханш 2020 оны 6-р сараас хойш маш тогтвортой байна. Гадаад валютын албан нөөц сүүлийн 4-5 сард 500 орчим сая ам.доллараар нэмэгдэж 4.9 тэрбум ам.доллар буюу түүхэн дээд хэмжээндээ хүрлээ. Энэ нь үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортой байдалд маш чухал үзүүлэлт юм. Экспорт улам сэргэвэл төгрөг илүү чангарах боломж бий гэж харж байна.

Төв банк эдийн засаг 2021 онд 6 хувиар өснө гэж төсөөлж байснаа өмнө нь мэдээлсэн. Тэгэхээр үүнд хангалтай хүрэхүйц нөхцөл байдал үүссэн гэж ойлгож болох уу?

-Хуулийн дагуу төв банк жил бүрийн намар Төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлээ боловсруулж, УИХ-аар батлуулдаг. 6 хувь гэдэг бол энэхүү үндсэн чиглэлийг боловсруулахдаа гаргасан төсөөлөл юм. Энэ төсөөлөл нь олон улсын санхүүгийн байгууллагуудынхтай ойролцоо байгаа. Нэгдүгээр улирлын дүн, одоогийн нөхцөл байдлыг харвал 6% -ийн өсөлт гэдэг нь хангалттай хүрэх боломжтой зорилт. Банкаараа дамжуулж санхүүгийн зуучлалыг сайн гүйцэтгэвэл эдийн засаг 8-9 хувиар өсөх боломж ч бий.

Ирэх онуудад төлөгдөх өндөр дүнтэй өр төлбөрүүдийг төлөх боломж, нөхцөл ямар байгаа вэ?

-Өрийн дарамт багасч байна. Өнгөрсөн онд ХХБ анх Засгийн газрын баталгаатайгаар гаргаж байсан 500 сая ам.долларын бондоо төлж, Чингис, Мазаалай бондын тодорхой хэсгийг Засгийн газар дахин санхүүжүүллээ. Дахин санхүүжилтийн үлдэгдэл болох 100 гаруй сая ам.долларыг өнгөрсөн сард төлж дуусгаад байна. Дээр дурдсанчлан валютын нөөц хуримтлагдаж байгаа тул ирэх жил хуваарийн дагуу төлөх бондуудыг цаг

“Төв банк цар тахлын үед ямар арга хэмжээ авч хэрэгжүүлбэл эрсдэлийг хохирол багатай давж, хурдан сэргээж, тогтворжуулах вэ гэдэг тал дээр богино, дунд, урт хугацааны төлөвлөгөө гаргаж ажиллаж байна. Авсан голлох арга хэмжээнүүдээс дурдвал төв банкны үнэт цаасны хүү буюу бодлогын хүүг цар тахал гарснаас хойш нийтдээ 5 нэгжээр буулгаж түүхэн доод хэмжээ 6 хувьд хүргэлээ.”

хугацаанд нь асуудалгүй төлөх боломжууд илүү бүрдээд байна.

Сүүлийн жилүүдэд Монголбанк иргэдийн санхүүгийн дарамтыг бууруулахад чиглэсэн бодлого авч хэрэгжүүлсэн. Энэ нь цар тахлын хямралын үед ямар нөлөө үзүүлэв?

-Монголбанк бодлогын арга хэмжээгээ цаг хугацаанд нь, зөв авч хэрэгжүүлсэн учраас өнөөдрийн амжилт, үр дүн гарсан гэдэгтэй маргах хүн байхгүй байх. Таны дурдсан иргэн, ААН-ийн зээлийн дарамтыг бууруулахад манай бодлогын шийдвэрүүд үр дүнгээ өгсөн гэж үзэж байна.

Цар тахлын дэгдэлт 2020 оны эцэс гэхэд хяналтад ороогүй учраас анх гаргасан зээлийн хугацааг сунгах, хөнгөлөх зэрэг арга хэмжээ энэ оны 7-р сарын 1 хүртэл үргэлжлэхээр байна.

Өр төлбөрийн дарамтыг бууруулах эдгээр арга хэмжээнд банкны системийн нийт зээлийн 30 гаруй хувь нь хамрагджээ. Өөрөөр хэлбэл ААН, иргэдийн 4 их наяд төгрөгийн зээлийн төлөлт хойшлогдсон гэсэн үг. Мөн ипотекийн хөнгөлөлттэй зээлийн үндсэн өр, хүүгийн төлбөрийг хойшлуулах арга хэмжээнд 60 мянган зээлдэгчийн 4 их наяд төгрөгийн зээл хамрагдаад байна. Дээрх арга хэмжээнүүдийн үр дүнд өрхийн өрийн дарамт хөнгөлөгдсөн гэдэгт итгэлтэй байна.

Мөн Засгийн газрын хэрэгжүүлж буй ₮10 их наядын хөтөлбөрийн хүрээнд хоёр сар хүрэхгүй хугацаанд 3 хувийн хүүтэй 960 тэрбум төгрөгийн зээл олгогджээ. Үүнд 2400 ААН, 11 мянган иргэн хамрагдсан гэдэг нь ямар их хэмжээний мөнгө богино хугацаанд зах зээлд орж, бизнесээ тогтвортой авч үлдэх, ажлын байрыг хадгалахад дэмжлэг болсон нь харагдаж байна. Үүнээс гадна 400 гаруй тэрбум төгрөгийн репо санхүүжилт олгогджээ. Өөрөөр хэлбэл өндөр хүүтэй авсан зээлээ дахин санхүүжүүлж, хүүний дарамтыг бууруулах боломж ААН-үүдэд олдсон юм.

Яриагаа банкны салбарын хөгжил рүү эргэн чиглүүлье. Хөл хорионы үед иргэд банкны үйлчилгээг цахимаар авлаа. Дэлхий даяар цахим шилжилт идэвхтэй хийгдэж байгаа энэ үед банкны салбарын түвшин хаана явааг харуулсан том шалгалт боллоо шүү дээ.

Бидний амьдарч буй цаг үе бол Аж үйлдвэрийн 4 дэх хувьсгал буюу цахим технологийн эрин үе. Энэ хувьсгалд банкны салбар тэргүүн эгнээнд явж байна. Дотоодын банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний 90 хувь нь цахимжжээ. Бүтээгдэхүүн цахимжина гэдэг нь орчин үетэйгээ хөл нийлүүлж байгаагаас гадна харилцагчиддаа түргэн шуурхай, амар хялбар үйлчилгээ үзүүлж байгааг харуулж байна.

Мөн цахим шилжилтэд бусад салбарыг араасаа дагуулаад, дэмжээд явж байгаа гэж хэлж болно.

Зохицуулах байгууллага буюу Монголбанкны хувьд зайлшгүй хийх ёстой зүйл нь дэд бүтэц. Жижиг компани эсвэл аливаа нэг банк ямар нэг технологийн шийдлийг олж болно. Тэрийг нь нийтэд хамруулж, хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд заавал нэг дэд бүтэц байх ёстой. Тиймээс Монголбанк Үндэсний цахим гүйлгээний төвийг шинэчилж, төлбөр тооцооны чиглэлд дэлхийн түвшний дэд бүтцийг бий болголоо. Мөн картын технологийг шинэчилж EMV стандартад шилжүүлж байна. Ингэснээр хэрэглэгчдийг гэмт халдлагад өртөхөөс сэргийлэх боломжийг бий болголоо.

Энэ онд банкны хөгжлийг дараагийн шатанд нь хүргэхүйц жинтэй зохицуулалтууд Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлтөөр ороод байна. Хуулийн өөрчлөлтийг төв банк түүчээлэн хийсэн гэж хардаг. Цаг үеийн нөхцөл шаардлага юу байв. Мөн банкны шинэчлэлийн үр дүнг хэрхэн төсөөлж байна?

Банкны салбар байнга шилжин хувьсаж байх ёстой. Олон улсын сайн стандарт жишгүүдийг нэвтрүүлж байвал салбар өөрөө тогтвортой байж, хөгжлийг түүчээлэх боломж нь бүрдэнэ. Монгол Улсад 12 арилжааны

банк байна. Салбарын 80 орчим хувийг системийн нөлөө бүхий 5 банк бүрдүүлдэг. Үүний 3 нь бараг 60 хувийг нь бүрдүүлдэг. Хувь нийлүүлэгчид нь төвлөрөл өндөртэй.

2008 оны дэлхий нийтийг хамарсан санхүүгийн хямралын үеэр санхүүгийн салбар нь хүндрэлд ороод зогсвол эдийн засаг дагаад зогсдог гэдгийг олон улсын жишээ харуулсан билээ. Тухайлбал Исланд, Грек улсын банкны салбарын үйл ажиллагаа нь зогсоход эдийн засаг нь дагаад унаж байсан жишээ бий. Тиймээс санхүүгийн салбарыг тогтвортой байлгах чиглэлд авсан олон улсын арга хэмжээнд суралцаж, хууль эрх зүйн зохицуулалтыг шинэчиллээ.

2021 онд УИХ-аас Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж баталлаа. Энэ хүрээнд банкны хувьцаа эзэмшигчдийн хувь эзэмшлийн төвлөрөлд 20 хувийн хязгаар тогтоож байгаа. Ингэснээр банк багадаа 5 хувьцаа эзэмшигчтэй болох бөгөөд олон нийтэд хувьцаагаа арилжаалсан буюу нээлттэй ХК-ийн хэлбэрт орно. Жижиг банкууд хаалттай хэлбэртэй байж болох бол том банкууд заавал нээлттэй компани болох ёстой гэсэн үг. Энэхүү зохицуулалтууд нь банкны секторын хөгжилд хувьсгал болохуйц гэж хүлээж байна.

Төв банкны үндсэн зорилт болох инфляцын түвшин эдийн засаг эргэн сэргэснээр нэмэгдэж, зорилтоос давах эрсдэл бий юу. Бодлогын арга хэмжээнд бэлэн үү?

Цар тахлаас үүдэж эдийн засаг хүчтэй унах ч эргэн огцом буюу V хэлбэрээр сэргэх боломжтой гэж анх судлаачид үзэж байсныг эргэн санаж байна. Монгол Улсын хувьд ч огцом унаж, огцом сэргэх хандлагатай байгаа юм. Үүнтэй холбоотойгоор инфляц өндийж, 4-р сарын байдлаар 5.6 хувьтай гарлаа. Монголбанк инфляцын зорилтоо $6 \pm 2\%$ хувийн интервалтайгаар тогтоож, мөнгөний бодлогодоо тусгаад байна. Эдийн засаг сэргэж буйтай холбоотойгоор инфляцад тодорхой дарамт гарах ч бодлогын хүрээндээ бид үүнийг тогтвортой барьж чадна.

Инфляц сэргэж байгаа нь зөвхөн Монголд болж буй зүйл биш бөгөөд олон улсад энэ талаар талаар идэвхтэй ярьж байна. Тиймээс инфляц эрчимжих нь эдийн засаг сэргэж буйтай холбоотой түр зуурын шинжтэй бөгөөд хяналтаас алдахаар асуудал биш юм.

Цар тахал бүрэн хумигдаагүй байгаа энэ үед Монголбанк мөнгөний бодлогын төлөвийг нэг хэсэгтээ зөөлрүүлсэн хэвээр байлгах нь ойлгомжтой. Мөн

Засгийн газрын хэрэгжүүлж буй ₮10 их наядын хөтөлбөрийг дэмжих боломж хэвээр байна. Репо санхүүжилт, ипотекийн зээлээ ч хэвийн үргэлжлүүлнэ. Эцэст нь хэлэхэд эдийн засаг сэргэж буйтай холбоотойгоор бизнесүүд эргэж хэвийн харилцаанд орно. Тиймээс төв банк тухайн үед нь таарсан мөнгөний бодлогыг явуулахаар арга хэрэгслүүдээ бэлдээд байна.

БНМАУ-ЫН БАНКНЫ ХУУЛЬ

БНМАУ зах зээлийн харилцаанд шилжсэнээр эдийн засгийн шинэ нөхцөл байдал бий болов. Тухайн үед мөрдөгдөж байсан Улсын банкны хууль, дүрэм зах зээлийн эдийн засгийн нөхцөлд тохирохгүй болсон тул банкны тухай хуулийн төслийг яаравчлан боловсруулж, батлуулах шаардлага тулгарчээ.



1990 онд БНМАУ-ын Улсын банкны Ерөнхий хороо банкны хуулийн төслийг боловсруулах комисс байгуулав.

1991 оны гуравдугаар сарын 19-нөөс БНМАУ-ын Улсын Бага Хурал банкны үйл ажиллагааны тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлжээ. Улсын Бага Хурал Засгийн газрын тэргүүн шадар сайд Д.Ганболдын илтгэл, хуулийн төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал дүгнэлтийг сонссоны дараагаар хуулийн үзэл санааны талаар

асуулт хариулт эхэлжээ. Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгээр хамгийн их маргаантай байсан хэд хэдэн асуудал байсны нэг нь банк нь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхийг хориглох эсэх асуудал байв. Хэлэлцүүлгийн явцад Улсын Бага Хурлын гишүүдийн олонх нь банк аж ахуйн үйл ажиллагаа

эрхлэх ёсгүй гэж үзэж байгаагаа илэрхийлжээ. Дараагийн асуудал нь мөнгөн тэмдэгт нэгжийн асуудал байв. Хуулийн төсөлд “БНМАУ-ын мөнгөн тэмдэгтийн албан ёсны нэгж нь төгрөг мөн. Нэг төгрөг зуун ширхэг нэгтийн нэгжтэй тэнцэх бөгөөд зоосыг мөнгө гэж нэрлэнэ” гэж томъёолсон бол Г.Зуунай, Б.Чимид нар бутархай мөнгийг зоос гэж нэрлэх саналтай байжээ. Тэд мөнгөн тэмдэгт, зоосыг нийлүүлээд мөнгө хэмээн тэмдэглэдэг атал бас зоосыг мөнгө хэмээн давхардуулан хоёрдмол утгатай нэрлэж ирсэн нь зохимжгүй гэж үзэж байв. Харин Д.Данзан, М.Энхсайхан нар “хэрэв бутархай мөнгийг зоос гэж нэрлэвэл бүх металл мөнгийг шинээр үйлдвэрлэхэд хүрч асар их зардал гарна... Хүмүүст мөнгөний реформ хийх нь гэсэн буруу зөрүү

ойлголт төрүүлж будлиан үүснэ” гэж өөрсдийн үндэслэлээ тайлбарлаж байв. Гишүүн Г.Зуунай “...улсын сүлдийг тэртэй тэргүй өөрчлөх шаардлага гарна. Хуульдаа зөв нэр томъёогоор тусгаж өгмөөр байна” гэж өөрийн саналаа нотлохыг оролдож байв. Удаах маргаантай асуудал нь төв банкны нэршил байв. Гишүүд “Үндэсний банк”, “Төв банк”, “Монгол Үндэсний банк” гэж нэрлэх санал гаргацгаажээ. Санал хураалтын дүнд “Төв

банк” гэж нэрлэхээр болсон байна. Түүнчлэн Төв банкны тогтолцооны талаар өгүүлсэн 8 дугаар зүйлд “а. Төв банкны удирдах дээд байгууллага нь Төв банкны захирагчдын зөвлөл байх ба тэр нь гурван ангиллын есөн гишүүнээс бүрэлдэнэ. Үүнд нэг дэх ангилалд арилжааны гурван банкны Ерөнхийлөгч нар; хоёр дахь ангилалд улс ардын аж ахуйн зонхилох гурван салбарын сайд нар; гурав дахь нь Төв банкны Ерөнхийлөгч, тэргүүн дэд ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч нар хамаарна. б. Төв банкны захирагчдын зөвлөлийн дарга нь Төв банкны Ерөнхийлөгч байна, Ерөнхийлөгчийг УБХ-аас 7 жилийн хугацаатай томилно. в. Төв банкны захирагчдын зөвлөлийн хоёр дахь ангиллын гишүүдийг Ерөнхий сайдын өргөн мэдүүлснээр, бусад гишүүнийг Төв банкны Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлснээр УБХ-аас 5 жилийн хугацаатай томилно” гэснийг хэлэлцээд гишүүд удтал маргалдан тохиролцож чадалгүй завсарлажээ. Гол маргаан захирагчдын зөвлөлийн дарга Төв банкны Ерөнхийлөгч байх, зөвлөлийн бүрэлдэхүүнд Засгийн газрын гурван гишүүнийг оруулах, зөвлөл нь яамдыг шууд удирдах эрх эдлэх эсэх асуудлыг тойрч өрнөжээ. Ингээд төсөлд тусгасан хувилбарыг үндсээр нь өөрчилж Төв банкны Ерөнхийлөгчийг УБХ-ын даргын өргөн мэдүүлснээр УБХ-аас 7 жилийн хугацаатай томилохоор шийдвэрлэсэн байна. 1991 оны дөрөвдүгээр сарын 2-ноос банкны хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг эхэлжээ. Анхны хэлэлцүүлгийн явцад гишүүдээс гаргасан санал, шүүмжлэлийг хэрхэн тусгасан тухай Эдийн засгийн байнгын хорооны гишүүн Д.Батсүх тэмдэглэхдээ “...зарчмын чанартай 12, үг найруулгын 30 орчим засвар хийсэн” гэж мэдэгджээ. “Банк, банкны үйл ажиллагааны тухай хууль” гэж байсныг “Банкны хууль” болгон өөрчилсөн байна. 2-р бүлгийн хэлэлцүүлэг их маргаантай байж, БНМАУ-ын мөнгө зээлийн бодлогыг хэрэгжүүлэх эрх бүхий эмиссийн банкны нэрийг Төв банк гэхийн сацуу оноосон нэр өгөх нь зүйтэй гэцгээн “Монголбанк” гэж нэрлэхээр тогтжээ. Төв банкны тогтолцооны талаар гишүүд санал зөрөлдөж, Эдийн засгийн байнгын хорооны

дарга М.Энхсайхан нарын гишүүд Засгийн газар ба Төв банкны үйл ажиллагааг холбох арга механизмыг олж тусгахыг санал болгож байв. Тэд Төв банкны Ерөнхийлөгчийг УБХ-ын даргын бус Ерөнхий сайдын өргөн мэдүүлснээр УБХ-аас томилох нь зохимжтой гэж үзэж байв. Ийнхүү удтал хэлэлцсэний эцэст Улсын Бага Хурал 1991 оны дөрөвдүгээр сарын 4-нд БНМАУ-ын банкны хуулийг 71.9 хувийн саналаар баталжээ. Хуулийг 1991 оны тавдугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр болжээ. БНМАУ-ын банкны хууль нь 4 бүлэг, 46 зүйлтэй. Хуульд мөнгөн хөрөнгө хуримтлуулан хадгалж өөрийн нэрийн өмнөөс бусдад зээлдүүлэх, мөнгөн гүйлгээ эрхлэх, харилцах дансны ажил, гүйлгээ явуулдаг байгууллагыг банк хэмээн тодорхойлж, БНМАУ дахь банкны тогтолцоо нь БНМАУ-ын Төв банк, арилжааны банкнаас бүрдэнэ гэж хуульчилжээ. Банкинд материаллаг үйлдвэрлэл эрхлэх, бүх төрлийн даатгалын үйл ажиллагаа явуулах, газрын зах зээлд ажиллахыг хоригложээ. Ийнхүү БНМАУ-ын банкны хууль батлагдсанаар нэгд, хоёр шатлалт банкны тогтолцооны эрх зүйн үндэс бүрдэв; хоёрт, Төв банкнаас олон улсын ба дэлхийн банкнуудтай харилцах эрхийг хуульчлав; гуравт, урьд банк нь Засгийн газарт шууд харъяалагдаж түүний хэрэгсэл болж байсныг өөрчилж Засгийн газраас хараат бус зарчмаар үйл ажиллагаагаа явуулах боломжтой болов; дөрөвт, Төв банк ба арилжааны банкнуудын эрх үүрэг, харилцаа холбоог тогтоож өгчээ.

*Эх сурвалж: Монголбанк,
түүхийн альманах*

1990 оны долдугаар сарын 27-нд "Үйлдвэрийн хувь нийлүүлсэн банк" байгуулахыг зөвшөөрсөн бөгөөд тус банк нь байгуулагдсан цагаасаа зах зээлийн өрсөлдөөн, менежментийн бодлого, маркетингийн онцлогтойгоо уялдуулан 1998 онд Шинэчлэл банк, 2003 оноос Капитал банк нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байв.



ХОЁР ШАТЛАЛТ БАНКНЫ ТОГТОЛЦОО ТӨЛӨВШСӨН НЬ

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1990 оны 422 тоот тогтоолын дагуу тус улсад аж ахуйн банк байгуулахыг зөвшөөрсөн нь Монгол Улсад банкны хоёр шатлалт тогтолцоо бий болох үндэс тавигджээ.

БНМАУ-ын Улсын банкны Ерөнхий хорооноос 1990 оны есдүгээр сарын 6-нд аж ахуйн банк байгуулах, түүнд зөвшөөрөл олгоход баримтлах аргачлалыг боловсруулан гаргасан байна. Дээрх дүрэм, аргачлалын дагуу БНМАУ-д хувь нийлүүлсэн аж ахуйн банк болон Улсын банкны Ерөнхий хорооноос тэнцэл тусгаарлаж төрийн өмчит Худалдаа хөгжлийн банк, Хөрөнгө оруулалт, технологи шинэчлэлийн банк байгуулагдсан юм. БНМАУ-ын банкны хуулийг 1991 оны дөрөвдүгээр сарын 20-нд БНМАУ-ын Ерөнхийлөгч батламжилж, улмаар мөн оны тавдугаар сарын 1-нээс эхлэн уг хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэв. БНМАУ-ын банкны хуульд "БНМАУ дахь банкны тогтолцоо нь БНМАУ-ын Төв банк, арилжааны банкнаас бүрдэнэ" хэмээн хуульчилж, мөнгө зээлийн бодлогыг хэрэгжүүлэх эрх бүхий эмиссийн банк нь БНМАУ-ын Төв банк байхаар тусгажээ. БНМАУ-д хувь нийлүүлсэн, хязгаарлагдмал хариуцлагатай, гадаадын хөрөнгийн оролцоотой төрийн ба хувийн арилжааны банк байгуулах түүний сацуу гадаадын банк, түүний салбар үйл ажиллагаагаа явуулахыг зөвшөөрчээ. Мөн Монголбанк нь хуульд цаасны дагуу зохицуулах, хянан шалгах үүргээ хэрэгжүүлэхдээ арилжааны банкны бие даасан байдлыг алдагдуулахгүй байх зарчим баримтална хэмээн хуульд заажээ. Монгол Улсад хоёр шатлалт банкны тогтолцоо үүсэн хөгжсөн үеийг судлаачид гурван үед хуваан авч үздэг.

ХОЁР ШАТЛАЛТ БАНКНЫ ТОГТОЛЦООНЫ ЭХЭН ҮЕ



Хадгаламж банкныг татан буулгав. /2013.07.22/

Хоёр шатлалт банкны тогтолцоо үүссэн эхэн үе буюу 1991-1993 онд банкны тусгай лицензийг 30 банк эзэмшиж байв. Гэвч 1991 онд БНМАУ-ын Төв банкны зүгээс мөнгөний бодлого явуулах институциональ дэд бүтэц, арга туршлага, банкнуудыг хянах хяналт шалгалтын систем хараахан бүрдээгүй байв. Иймээс нийт мөнгө буюу М2 1991 онд 77 хувиар, 1992 онд 32 хувиар, 1993 онд 227 хувиар хяналтгүй өсөж, улсын инфляц 1992 онд дээд цэгтээ буюу 325 хувьд хүрчээ. Төв банкнаас мөнгөний бодлогоо явуулах институциональ дэд бүтцийг бий болгох талаар анхаарч ажиллажээ.

- 1991 оны тавдугаар сарын 1-нээс Банкны хуулийг мөрдөж эхлэв.
- 1991 оны сүүлийн хагаст Монголбанкнаас заавал байлгах нөөцийн хувь хэмжээ болон банкнуудаас иргэдийн хадгаламжид төлөх

хүүний доод хэмжээг тогтоожээ.

- 1992 оны наймдугаар сард клирингийн тооцоо нэвтэрснээр банкнуудын эх үүсвэрийг өөр хооронд нь тусгаарласан.
- 1992 оны есдүгээр сараас Монголбанкнаас арилжааны банкнуудын ажиллагаанд мөрдүүлэх зохистой харьцааг тогтоож эхлэв.
- 1992 оны 10 дугаар сард банкнуудын олгож болох зээлийн дээд хэмжээг тогтоож захиргааны хэрэгслээр мөнгөний нийлүүлэлтийг хязгаарлах болсон.
- 1993 оны гуравдугаар сард Монголбанкнаас эргэлзээтэй болон найдваргүй зээл тодорхойлох аргачлал
- 1993 оны долдугаар сард төгрөг, ам. долларын хөвдөг тогтолцоонд шилжсэнээр зах зээлийн хүчин зүйлс төгрөгийн ханшийг тодорхойлох болов.
- 1994 оны нэгдүгээр сараас нягтлан болох бүртгэлийн дансны шинэ төлөвлөгөөг хэрэгжүүлсэн. Ийнхүү банкны салбар дахь алдаа завхралыг залруулах арга хэмжээг авснаар 1993 он гэхэд мөнгөний бодлого явуулах хууль эрх зүйн орчин бүрэлдэж, мөнгөний бодлогын захиргааны шинжтэй арга хэрэгслүүд бий болов. Арилжааны банкнаас Монголбанкинд тэнцэл, орлого зарлагаа тайлагнан, Төв банкнаас арилжааны банкинд тавих хяналтын тогтолцооны суурь тавигджээ.

ХОЁР ШАТЛАЛТ БАНКНЫ ТОГТОЛЦООНЫ БОЙЖИЛТЫН ҮЕ

Арилжааны банкнуудаас судалгаагүй олгосон зээлжилтээс үүдэлтэй зээлийн чанар муудан, арилжааны банкнуудын төлбөрийн чадвар доройтон хямарч эхэлсэн буюу 1994-1999 оныг

хамаарна. Банкны хямралын голлох шалтгаан нь нэгд, зээл олголт хэт эрсдэлтэй, зээлийн эргэн төлөлт муудсанаар банкаар дамжин эргэх мөнгөн хөрөнгийн эргэлт саатсан; хоёрт, банкнуудын дотоод хяналтын систем тааруу, орон нутаг дахь салбарын үйл ажиллагаанд төвөөс тавих хяналт байхгүй байснаас эргэн төлөгдөхгүй зээлийг их хэмжээгээр олгосон; гуравт, банкнаас авсан зээлээ эргүүлэн төлөхгүй байх зорилго бүхий илт эрүүгийн шинж чанартай ажиллагаа зарим банкнууд дээр явагдсантай холбоотой гэж судлаачид дүгнэдэг. Хямралын хүрээ, учруулах уршиг, үргэлжлэх хугацаа зэрэг нь Төв банк бүтцийн өөрчлөлтөө хэр шийдэмгий хийхээс шалтгаалж байв.

ХОЁР ШАТЛАЛТ БАНКНЫ ТОГТОЛЦООНЫ ТОГТВОРЖИЛТЫН ҮЕ

1999 оны сүүл, 2000 оноос санхүүгийн зуучлалын үзүүлэлтүүд сайжрах хандлагатай болсноор тогтворжилтын үе эхэлсэн гэж үздэг. Банкны тогтолцоо тогтворжих таатай үе бүрэлдэж эхэлсэн нь өмнөх үйл ажиллагаанаасаа сургамж авч туршлагажсаны байв. Үүний үр дүнд харилцагчдын банкинд итгэх итгэл эрс дээшилж, 2001 онд их хэмжээний мөнгө харилцах, хадгаламжийн хэлбэрээр банк руу орж ирэх болж, тэр хэмжээгээр банкнуудын зээлийн хэмжээ нэмэгдэж санхүүгийн зуучлалын сувгууд сэргэсэн байна. 1999 оноос хойш төгрөг, ам. долларын харьцаа тогтвортой байж инфляцыг Монголбанк урьдаас таамаглахуйц түвшинд тогтвортой барьж ирэв. Мөн банк санхүүгийн салбарт шинээр банк болон банк бус санхүүгийн байгууллага олширч өрсөлдөөн мэдэгдэхүйц нэмэгджээ.

*Эх сурвалж: Монголбанк,
түүхийн альманах*

ХӨГЖИЛД ТЭМҮҮЛСЭН ЖИЛҮҮД



Г.ЭРДЭНЭБАЯР
ХЭЗГ-ын захирал
(2012-2016)
Монголбанк

Улсын Бага Хурлаас Монголын эдийн засгийг зах зээлийн эдийн засагт шилжүүлэх суурь хуулиуд болох Өмч хувьчлал, Аж ахуйн нэгжийн тухай хууль, Гааль, Татварын зэрэг хуулиудыг батлан гаргаж байсны нэг нь Банкны хууль мөн. Банкны секторыг зах зээлд шилжүүлэх анхны суурийг тавьсан хуулийн хувьд хэлэлцүүлгээр УБХ-ын гишүүд няхуур хандаж цаг их зарцуулж бараг бүхий л зүйл, заалт бүр ширүүн маргааны талбар болж байв.

Энэ хуулийн үндсэн ач холбогдол нь манай улсад 2 шатлалт банкны тогтолцоог бий болгосон, зах зээл хөгжсөн улсуудын тогтолцоотой төстэй болж, өмнөх системээс зарчмын ялгаатай банкны шинэ тогтолцоо бүрдсэн бөгөөд төв банк нь эдийн засгийн бодлого хэрэгжүүлэгч, зохицуулагч байгууллага болох үндэс нь тавигдсан юм. Төв банк, арилжааны банкны эрх зүйн агуулгыг тодорхойлж, тэдний үйл ажиллагаа, эрх үүргийг салгаж, зах зээлд тулгуурласан, орчин үеийн 2 шатлалтай банкны тогтолцооны үндсийг тавьсан нь Монголын эдийн засгийн шилжилт, шинэчлэлийн нэг чухал алхам болов.



М.СҮХЭЭ
УБЕХ-ны Шалган
байцаах хэлтсийн
дарга асан

Өмнө нь Мөнгөний бодлогыг улирал бүр төлөвлөж, Засгийн газраар батлуулж, Улсын банкны систем харьяа банкууддаа даалгавар өгч, хэрэгжүүлж байв. Зах зээлийн тогтолцоонд шилжихтэй холбоотой макро эдийн засгийн тулгуур хүчин зүйл болсон мөнгөний бодлогыг зохицуулах бодитой хууль хэрэгтэй гэж үзэж байсан юм. Банкны хуулиар мөнгөний бодлогыг барьдаг ямар байгууллага байхыг шийдэх болсон билээ. Энэ дагуу Төв банк мөнгөний бодлого, гүйлгээнд байх мөнгөний хэмжээг тодорхойлж, байгууллага, иргэдийг бэлэн мөнгөөр хангах үйл ажиллагааг арилжааны банкуудаар дамжуулж гүйцэтгэх, төгрөгийн ханшийг хариуцах зэрэг мөнгөтэй холбоотой том бодлогыг хариуцах боллоо. Мөн төв банкнаас арилжааны банкуудыг салгаж бий болгосон юм. Тухайлбал Улсын банкны Гадаад тооцооны газрыг орон тоо, цалин, тоног төхөөрөмжтэй нь Худалдаа хөгжлийн банк байгуулж шилжүүлсэн бол Хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх газрыг Хөрөнгө оруулалт, Технологийн шинэчлэлтийн банк байгуулж, шилжүүлж байсан юм.



Д.МОЛОМЖАМЦ
Монголбанкны
Ерөнхийлөгч
(1992-1996)

Нийгмийн тогтолцоо өөрчлөгдөж, манай улс зах зээлийн харилцаанд шилжиж эхэлсэн эхний жилүүдэд Улсын банк гэсэн банкны монополий систем задарч, төв банк, арилжааны банк гэсэн хоёр шатлал бүхий тогтолцоо үүсэж хөгжих түүхэн мөчлөгийн үед Монголбанкны ерөнхийлөгчөөр томилогдон ажиллаж байлаа. Хоёр шатлалт тогтолцооны хүрээнд хийгдсэн нэг том алхам бол Төрийн мөнгөний бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх байсан юм. 1992 онд Төрийн мөнгөний бодлогын анхны төслийг хийж, Улсын Бага Хурлаар хэлэлцүүлж, батлуулж байлаа. Ингэснээр төв банкны эрх үүргийн дагуу арилжааны банкуудад ямар хяналт тавих, арилжааны банкууд Монголбанкны өмнө ямар үүрэг хариуцлага хүлээх ёстойг хуульчилж заасан анхны Төрийн мөнгөний бодлогын баримт бичиг гарч байсан түүхтэй.

Мөн 1993 оныг хүртэл төгрөгийн валюттай харьцах ханшийг дээрээс тогтоож байв. Энэ байдлыг бид өөрчилж, валютын ханшийн чөлөөт тогтолцоонд шилжих арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлсэн билээ. Энэ нь УИХ-ын сонгуультай давхцаж маш их улс төржсөн, хэцүү асуудал байлаа. Үүнийг хэдэн оноос, яаж зарлах вэ гэдгийг бие дааж шийдэхэд миний хувьд хамгийн эгзэгтэй, хэцүү зорилт байв.



Ж.ҮНЭНБАТ
Монголбанкны
Ерөнхийлөгч
(1996-2000)

1990-ээд оны эхээр анхны хувийн банкууд байгуулагдсан ч төрийн өмчийн банкууд давамгайлж, түүнийг ажиллуулж байсан хүмүүсийн сэтгэлгээ, ур чадвар, үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин, дэд бүтэц хуучин байсан учраас дампуурах нь цаг хугацааны асуудал байлаа. Банкууд төлбөрийн чадваргүй болж, нэг банкнаас нөгөөд шилжүүлэх мөнгө нь алга болчихдог, төв банкны тусламжаас шууд хараат байсан тул хариуцлагатай болгохоор эрх зүйн шинэчлэл хийж, системийн ач холбогдолтой томоохон банкуудыг татан буулгаж, салбарыг эрүүлжүүлсэн. 1990-ээд оны банкны хямрал бол дээр дурдсан цаг хугацааны хүчин зүйлсээс хамаарсан хямрал байсан учир засах арга хэмжээг тууштай авсан юм. Эдгээрийн үр дүнд үе үе гардаг хямралыг даван туулах чадвартай, хувийн хэвшил давамгайлсан эдийн засаг, банкны салбартай болж, улмаар санхүүгийн зуучлал бүрэн утгаараа эдийн засагт үүргээ гүйцэтгэх болсон билээ.



Л.ПҮРЭВДОРЖ
Монголбанкны
Ерөнхийлөгч
(2009-2012)

2009 оны хямралыг даван туулахын тулд шийдвэртэй арга хэмжээ авч Мөнгөний бодлогыг эрс буюу 4.25 нэгж хувиар чангалж байв. Мөн 2009 оныг хүртэл Монголд валютын харьцаа зах зээлд орж чадаагүй байсан юм. Монголбанк том үйлдвэрүүдээс валютаа авч, арилжааны банкуудад өгч, заримд нь зориулалт зохиож өгдөг байсныг эрс өөрчлөлт хийх шаардлагатай байлаа. Тиймээс валютын дуудлага худалдаагаар зах зээлийн дэг жаяг, журамд нь оруулсан нь шийдвэрлэх арга хэмжээ болсон билээ. Төсвийн бодлого эхний хугацаанд их сайн байсан бөгөөд мөнгөний бодлого, төсвийн бодлого нийлснээр асуудал түргэн засарч, хямралаас гарах боломжоо богино хугацаанд хангаж байв. Гэвч сүүлд нь Засгийн газар бодлогоо өөрчилсөн. Тухайн үед төв банк эдийн засгийг тогтворжуулах, дунд хугацаанд хөгжлийн боломжийг хадгалж үлдэх тал дээр шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж, мөнгөний бодлогыг бүх чиглэлд хатуу байлгасан. Мөн макро бөгөөд микро зохистой харьцааны үзүүлэлтийг шинэчлэх, түүнийг ашиглах тал дээр ахиц, дэвшил гаргасан байдаг. Санхүүгийн хяналтын бодлогоор хүртэл тогтвортой байдлыг хадгалж үлдэх, жолоо цулбуурыг нь тавиад туучихгүйгээр дараагийн улсуудад хүлээлгэж өгөх үүрэг гүйцэтгэж байсан гэж хэлж болно. Энэ бол том сургамж. Төсөв өөрийнхөө хэмжээнд тохирсон, мөчлөг сөрсөн, сайхан үед нь нөөцөө бүрдүүлдэг, тааруу үед нь хумьдаг, нөөцөөсөө санхүүжүүлдэг, мөнгөний бодлого нь дунд, урт хугацааны хөгжлийг харгалзаж явбал монголын эдийн засаг гадаад нөлөөлөл ихтэй ч зөөлрүүлэх боломж бий. Тэгэхгүй бол ямар үр дүнд хүрдгийг харуулсан. Нэг үгээр хэлбэл тухайн үед бий болсон боломжийг төсөв улс төржсөн учраас цацсан. Харин бодит эдийн засгаа дэмжих боломжийг төв банк мөнгөний бодлогоор ашиглаж чадаагүй. Учир нь зэрэгцээд явбал бид хямралд орчих гээд байсан. Ийм зүйлийг бодож, түүхээсээ харж байвал хамгийн сургамжтай.



Б.ЖАВХЛАН
Монголбанкны
Тэргүүн Дэд
Ерөнхийлөгч
(2010-2015),
Монгол Улсын
Сангийн сайд

2002-2003 оны үед эрсдэлд суурилсан банкны хяналт шалгалтын тогтолцоонд шилжиж эхэлсэн гэж үздэг. Энэ шилжилтийн процесс тийм ч хурдан болоогүй. Дотооддоо боловсон хүчнээ бэлдэхээс гадна Базелийн хороонд нэгдсэн гадны төв банкуудын хувьд ямар сайн тал, эрсдэл байна, юун дээр анхаарах вэ зэрэг туршлагаадаас суралцахад хугацаа шаардаж байв. Энэ тогтолцоонд эрчтэй шилжсэн хугацааг 2008 оноос хойш гэж би үзэж байна. 2010-2012 онд эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоонд 80-90 хувьтай шилжсэн гэж болно. Төв банк баримтад суурилсан хяналт шалгалтыг хийхээ больсон бөгөөд эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоо бэхжиж, арилжааны банкуудыг үүнд бэлтгэсэн юм. 2014 он гэхэд бодлогын шилжилтүүд бүрэн хийгдсэн бөгөөд банкууд хяналт шалгалтын тогтолцоондоо дасан зохицож, дотооддоо реформын шинжтэй өөрчлөлтүүд хийж чадсан гэж боддог.



О.ЭРДЭМБИЛЭГ

Монголбанкны
Тэргүүн Дэд
Ерөнхийлөгч
(2016-2020)

2016 оны наймдугаар сард Мөнгөний бодлогын хороо хуралдаж бодлогын хүүг 4.5 нэгж хувиар өсгөж байлаа. Шалтгаан нь эдийн засаг дахь илүүдэл нөөц ханшин дээр дарамт учруулж, банкуудын тайлан тэнцэлд сөргөөр нөлөөлөх түвшиндээ хүрч байсантай холбоотой. Мөн эдийн засаг, бизнесийн идэвх суларч, тухайн оны гурав, дөрөвдүгээр улиралд дефляцтай гарч байв. Тэрхүү мөнгөний бодлогын хорооны хурлаар авсан арга хэмжээ бол банк санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилготой. Үүнтэй зэрэгцэн ОУВС-ийнхантай яриа хэлэлцээ эхэлж, хөтөлбөр 4-р сард батлагдсан юм. Хөтөлбөр батлах, хэлэлцээ хийх явц Монгол Улсын гадаад зах зээл дэх бондуудын эргэн төлөгдөх хугацаа дуусахтай давхцаж байв. Монгол Улс өмнө нь гол төлөв "Стэнд бай" хөтөлбөр хэрэгжүүлж байсан ч тухайн үед "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр" хэрэгжүүлэхээр болсон билээ. Гол ялгаа нь бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээнүүд дээр төвлөрч ажиллах байсан юм.

Активын чанарын үнэлгээгээр ДНБ-ий 1.9 хувьтай тэнцэх хэмжээний өөрийн хөрөнгийн дутагдал гарав. Тухайн үед ОУВС-ийнхан 14 хувь, Монголбанк 2-2.5 орчим хувийн дутагдалтай байх болов уу гэсэн тооцоотой байсан юм. Эцсийн дүндээ Монголбанк буюу зохицуулагч байгууллага нь банкуудаа арай илүү мэддэг гэсэн дүр зураг гарч, хөрөнгө оруулагчдад итгэл бий болсон гэж үзэж байна. Тухайн үед авсан арга хэмжээнүүдийн үр дүнд 2019 он хүртэлх эдийн засгийн өсөлтүүд бий болсон гэж хувьдаа үздэг.




СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ТОЙМ

2021 оны 4 дүгээр сар


M2 МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ



M2 мөнгөний өсөлт 2021 оны 4 дүгээр сард 32.3%-д хүрэв



M2 мөнгөний өсөлт байршуулалт талаас



M2-ийн өсөлт эх үүсвэр талаас




Эх сурвалж: Монголбанк

1


ЗЭЭЛ



Банкуудын нийт зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 2.9%-иар өсч 17.5 их наяд төгрөгт хүрэв.



2021 оны 4 дүгээр сарын байдлаар чанаргүй зээл 11.4%-тай байна.



Зээлийн бүтэц, салбарын ангиллаар




Эх сурвалж: Монголбанк

2


ИПОТЕКИЙН ЗЭЭЛ




Ипотекийн нийт зээлийн үлдэгдэл 5,050.9 их наяд төгрөгт хүрэв.



Шинээр олгосон ипотекийн зээлийн хүү



Орон сууцны байршил



Зээлдэгчдийн тоо




101,073

Эх сурвалж: Монголбанк

3

ХҮҮ

Зээлийн хүү, хадгаламжийн хүүний зөрүү, хувиар




Зээлийн хүү*, хугацаатай хадгаламжийн хүү, хувиар (төлөвлөгөө, хөтөлбөрийн зээл оруулснаар)




4

ИНФЛЯЦ

Бодлогын хүү түүхэн доод түвшин 6 хувьд хүрэв.




2021 оны 4 дүгээр сарын байдлаар улсын хэмжээнд инфляц 5.6%-тай гарав



ХҮНСНИЙ ҮНИЙН ЖИЛИЙН ӨӨРЧЛӨЛТ

УЛААНБААТАР ХОТ




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

5

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

Төлбөрийн тэнцэл, сая ам.доллар




Төлбөрийн тэнцэл 2021 оны эхний 3 сарын байдлаар 170.4 сая ам.долларын ашигтай гарсан.



Урсгал ба хөрөнгийн дансны бүтэц



Санхүүгийн дансны бүтэц



Эх сурвалж: Монголбанк

6



ТӨВ БАНКИНД АЖИЛЛАХЫН УТГА УЧИР

Намайг Б.Тулга гэдэг. АНУ-ын Нью-Йорк хотын Baruch College-ийг төгссөн. 2019 оноос эхлэн Монголбанкны Төлбөр тооцооны газрын Хяналт зохицуулалтын хэлтэст хянан шалгагч-мэргэжилтнээр ажиллаж байна.

СОНГОЛТ & ШАЛТГААН

Би санхүүч мэргэжлээр бакалаврын зэргээ хамгаалж төгссөн. Мэргэжлээ сонгоход гэр бүлийнхэн маань их нөлөөлсөн юм. Тэд бүгд л эдийн засаг, санхүүгийн салбарын хүмүүс байдаг. Өвөө, аав хоёулаа банкирууд, тэр тусмаа Монголбанканд ажиллаж байсан. Бага байхдаа хүүхдийн гэнэн мөрөөдлөөр “Би ч гэсэн ирээдүйд төв банканд ажиллах болно” гэж боддог байлаа.

Гэрийнхэн маань надад авахыг хүссэн зүйл байгаа бол зардлаа хэмнэх бус орлогоо нэмэгдүүлж байж илүү хурдан зорилгодоо хүрч болох талаар зөвлөдөг байв. Одоо бодоход энэ нь миний үзэл бодол төлөвшихөд гол нөлөө болжээ.

Арван жилээ төгсөх үедээ өөрийгөө чухам юуг илүү сайн хийж чадах вэ гэдгээ бодож эргэцүүлсний эцэст шийдвэрээ гаргасан. Тухайн үед “Хүний амьдралд гэр бүл, найз нөхөд, хайр сэтгэл, аз жаргал гээд үнэт зүйл олон. Энэ бүхэнд мөнгө тодорхой хэмжээнд нөлөөлдөг. Зоосны хоёр тал шиг л зэрэгцэж байдаг юм байна” гэж бодоод мөнгө, санхүүтэй холбоотой ажил мэргэжил эзэмшиж, энэ талаар академик мэдлэг боловсролтой болох нь зөв хэмээн шийдсэн.

ЗАРЧИМ & ҮНЭТ ЗҮЙЛ

Миний ажиллаж буй хэлтэс арилжааны банк, байгууллагуудын үйл ажиллагааг хянаж, зөрчил илэрсэн тохиолдолд шаардлагатай арга хэмжээг авах, алдаа дутагдал, зөрчил гаргасан газрыг торгох хүртэл эрх бий. Үүнийгээ дагаад маш өндөр хариуцлагатай ажиллахыг шаардана.

Миний хэлсэн нэг үг ч Монголбанкны үг. Энэ том байгууллагыг төлөөлж буй учраас би хуулийн зүйл заалт, өөрийн эрх үүргээ бүгдийг нь тодорхой мэддэг байх ёстой. Нэг төгрөгийн зөрүү гарсан ч алдаа бол алдаа. Үүнийг хэрхэвч тоохгүй орхиж, “уучилж” болохгүй. Зохих шийтгэл арга хэмжээг эргэлзэлгүй хийж чаддаг байх ёстой.

БАХАРХАЛ & ЭРСДЭЛ

Хүн бүр л гар утсаараа интернет ашиглаж, эсвэл карт, АТМ-ын тусламжтайгаар мөнгө шилжүүлдэг. Гэхдээ энэ бүхний цаана ямар үйл явц өрнөж байгааг тэр бүр мэддэггүй. Харин манай ажлын гол үүрэг бол бүхий л гүйлгээ, төлбөр тооцоо цаг алдалгүй хэвийн явагдаж байгаа эсэхийг хянаж, гарсан асуудлыг шийдвэрлэх. Монгол Улсын хэмжээнд өдөр бүр, цаг минут тутамд хийгдэж буй төлбөр тооцооны урсгалыг хянахын тулд Монголбанкны Төлбөр тооцооны газрын Хяналт зохицуулалтын хэлтэс ажилладаг.

Хэдхэн жилийн өмнө банк хооронд картын гүйлгээ хийж болдоггүй байсныг Монголбанк нэгдсэн системд шилжсэнээр аль ч банк хооронд картын гүйлгээ дамжих дэд бүтэцтэй болсон. Түүнчлэн төрийн сангийн мөнгийг (хүүхдийн мөнгө, халамжийн мөнгө, хувьцааны ногдол зэрэг) иргэдийн хувийн данс руу шууд шилжүүлдэг гээд манай нэгдсэн систем “ид шидтэй” шүү.(инээв) Олон улсын стандартад нийцсэн, чанартай, хөгжингүй улс орнуудтай л ижил системээр үйл ажиллагаа явуулдаг юм. Дэлхийн банкнаас зөвлөхүүд ирээд Монголд ийм систем ажилладаг гэхээр “Яаж” гээд гайхаж билээ.

Мөн манай хэлтэс сар, улирал бүрийн тооцооны тайланг гаргаж бүх датаг хянадаг тул хариуцлага алдвал үүний цаана тухайн банк, ажилтнууд, харилцагчдын эрх ашигт шууд нөлөөлдөг. Иймд өөртөө үргэлж эргэлзэж байхгүй бол маш том эрсдэл дагаж явдаг.

ЭРЭЛТ & ҮНЭЛЭМЖ

Эдийн засаг, санхүүгийн чиглэлээр суралцдаг бол яг хаана, ямар албан тушаалд ажиллах нь нарийн тодорхой байхгүй. Ерөнхийд нь санхүүч, эдийн засагч гэж мэргэжил эзэмшдэг. Хэрхэн мэргэшиж ажиллахаа өөрөө л сайн судалж, төлөвлөх хэрэгтэй.

Дэлхий дахин тэр чигтээ цахимжиж байна. Өнгөрсөн оны гуравдугаар улирлын тайлангаар бэлэн бус гүйлгээ, бэлэн мөнгөний гүйлгээнээс илүү гарсан. Үүнээс Монголд ч цахим мөнгө, блокчейн, криптовалют гээд технологиуд маш эрчимтэй хөгжиж байгааг харж болох юм. Хүмүүс цахим мөнгө, шилжүүлэг ашиглахын хэрээр энэ үйл явцыг хариуцлагатайгаар хянах эрэлт хэрэгцээ байсаар байна. Тэгэхээр мэргэжлээ сонгох гэж буй хүүхэд залууст “Финтек”, санхүүгийн чиглэл, тэр дундаа цахим мөнгөний салбарыг сонирхож, судалж үзэхийг санал болгож байна.

БОЛОМЖ & ЗӨВЛӨМЖ

Мэргэжлээ сонгохоосоо өмнө сонирхож хүсэж байгаа зүйлээ хорин жилийн дараа хийсэн ч чи сэтгэл ханамжтай байж, санхүүгийн эрх чөлөөнд хүрч чадах уу гэдгийг нухацтай бодоорой. Хүн ер нь юу ч хийхийг хүссэн мөнгө санхүүгийн асуудал тодорхой хэмжээнд нөлөөлж байдаг шүү дээ. Тиймээс санхүүгээ сайн тооцоолж сурах зайлшгүй шаардлагатай.

Хүмүүс ихэнхдээ сонирхлоо дагаж сонголт хий гэдэг ч тухайн зүйлийг үнэхээр сайн хийж чадах уу гэдгээ бодох л ёстой. Хоосон мөрөөдлөөр харж, өнгөц шийдвэрлэж болохгүй. Жишээ нь зурах дуртай болохоороо зураач болно гээд зүтгээд байж болохгүй гэсэн санаа. Та үнэхээр бусдаас ялгарч, илүү сайн биш бол яагаад өөртөө хэрэгтэй зүйл сурч шинэ сонирхлоо нээж болохгүй гэж?

МОНГОЛБАНК

МӨНГӨНИЙ БОДЛОГО



1991

Хоёр шатлалт банкны тогтолцоонд шилжив

1993

Төв банкны үнэт цаас гаргав

1993

Валютын ханшийн хөвөх тогтолцоонд шилжив

1994

Мөнгөний үзүүлэлтийг онилох бодлогод шилжив

2001

Овернайт зээл, репо хэлцэл нэвтрүүлэв

2007

Бодлогын хүүг нэвтрүүлэв

2009

Төв банкны интервенцийг дуудлага худалдааны зарчмаар явуулж эхлэв

2018

Мөнгөний бодлогын хороо байгуулагдав

2018



Макро зохистой бодлого хэрэгжүүлж эхлэв

ИНОЛЦЫГ ОНИЛОХ

МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТ ОНИЛОХ



ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ (АМ. ДОЛЛАРААР, V/20 ӨДРИЙН БАЙДЛААР)



ОН ГАРСНААС ХОЙШ 4162 ИРГЭНД 307.6 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ИПОТЕКИЙН ЗЭЭЛ ОЛГОВ

Ипотекийн 6 хувийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтэд Монголбанк болон Засгийн газар, арилжааны банкууд хамтран 2021 оны эхнээс тавдугаар сарын 27-ны өдрийг хүртэлх хугацаанд 307.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдэж, 4162 өрхийг хамрууллаа.

Нийт олгосон зээлийн 246.5 тэрбум төгрөг нь (3019 зээл)

Улаанбаатар хотод, 61.1 тэрбум төгрөг нь (1143 зээл) хөдөө орон нутагт олгогджээ.

“Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний дагуу орон сууцны хөтөлбөрт 2021 онд Монголбанк болон Засгийн газрын эх үүсвэрээс нийт 700 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор ажиллаж байгаа нь өнгөрсөн 3 жилийн дунджаас 2-3 дахин өндөр дүн юм.

Түүнчлэн Монголбанкнаас “Ковид-19” цар тахлын үед нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор ипотекийн зээлийн эргэн төлөлтийг долоодугаар сарын 1 хүртэл хүү хуримтлуулахгүйгээр хойшлуулсан. Энэ хүрээнд нийт 3 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй, 55728 иргэн хамрагдаж, ипотекийн зээлийн төлбөрөө хойшлуулсан байна. Иргэд ипотекийн зээлийн эргэн төлөлтөө хойшлуулснаар сард дунджаар 227 тэрбум төгрөгийн үндсэн болон хүүний төлбөрөөс чөлөөлөгджээ.

АЖЛЫН БАЙРЫГ ДЭМЖИХ ЗОРИЛГООР 1 ИХ НАЯД 66.7 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ЗЭЭЛ ОЛГООД БАЙНА

“Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний дагуу иргэд, аж ахуйн нэгжүүдэд жилийн 3 хувийн хүүтэй ажлын байрыг дэмжих хөнгөлөлттэй зээлийг олгож эхэлсэн. Энэ хүрээнд тавдугаар сарын 27-ны өдрийн байдлаар 1 их наяд 66.7 тэрбум төгрөгийн 14,664 иргэн, аж ахуйн нэгжид зээлийг олголоо. Үүнээс 591.7 тэрбум төгрөгийн зээлийг Улаанбаатар хотод, 475 тэрбум төгрөгийн зээлийг хөдөө орон нутгийн иргэн, аж ахуйн нэгжид олгожээ. Түүнчлэн шинээр олгосон зээл 952 тэрбум төгрөг, дахин санхүүжилт 114.7 тэрбум төгрөг байгаа бол 19.2 тэрбум төгрөгийн 140 зээлд зээлийн батлан даалт гаргасан байна.

Нийт санхүүжилтийн 46.8 хувийг ХААН банк, 20.8 хувийг Төрийн банк, 14.8 хувийг Голомт банк, 10.8 хувийг Хас банк, үлдсэн 7 орчим хувийг бусад банкууд олгожээ. Банкуудад тавдугаар сарын 27-ны өдрийн байдлаар нийт 6 их наяд 2.4 тэрбум төгрөгийн дүн бүхий 55115 хүсэлт ирсэн байгаагаас 10919 хүсэлт судалгаанд байна.

РЕПО САНХҮҮЖИЛТЭЭР 424.1 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ЗЭЭЛ ОЛГОВ

Монголбанк он гарснаас хойш нэгдүгээр улиралд 300 тэрбум төгрөг, хоёрдугаар улиралд 275 тэрбум төгрөгийн репо санхүүжилтийг банкуудад олгоод байна. 2021 оны тавдугаар сарын 27-ны өдрийн байдлаар банкууд репо санхүүжилтийн хүрээнд нийт 424.1 тэрбум төгрөгийн зээлийг 2078 зээлдэгчид олголоо. Нийт зээлийн 336.7 тэрбум төгрөг нь (1219 зээл) Улаанбаатар хотод, 87.4 тэрбум төгрөгийн (859) зээл нь хөдөө орон нутагт олгогджээ. Түүнчлэн нийт зээлийн 78 хувь нь аж ахуйн нэгжүүдэд, 22 хувь нь иргэдэд олгогдсон байна.

Тавдугаар сарын 27-ны өдрийн байдлаар банкуудад нийт 699.4 тэрбум төгрөгийн дүн бүхий 2821 зээлийн хүсэлт ирээд байгаагаас банкууд 361 зээлийн хүсэлтийг судалж байна.

МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

Ховд аймгийн Цэцэг сумаас 3,047 гр
жинтэй төрц алт олдсоныг Монголбанк
худалдаж авсан. Монголбанкны
Эрдэнэсийн санд хадгалагдаж байгаа
хамгийн том төрц алт.



*Хоёр шатлалт
банкны тогтолцоо үүсэж хөгжсөний 30 жилийн ойд
зориулсан дурсгалын мөнгөн зоос*



Нэр: **₮-Карт**

Он: **2021**

Металл: **Мөнгөөр бүрсэн зэс зоос**

Жин: **61.1 грамм**

Диаметр: **85 x 55 мм**

Үнэ: **350,000₮**

Сорьц: -

Цуврал: **Монголбанкны ойн баяр**

МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭНЦЭХ ТОГТОЛЦООНД ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭГ ХИЙЖ БАЙНА

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын Зөвлөмж 1-т заасны дагуу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хийж, уг үнэлгээний үр дүнд суурилан Үндэсний хөтөлбөрийг боловсруулахаар заасан. Энэ хүрээнд 2016 онд анхны Үндэсний эрсдэлийн үнэлгээний тайланг боловсруулж гаргасан. Тийм учраас Санхүүгийн мэдээллийн албанаас санаачлан Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг Дэлхийн банкны аргачлалын дагуу хийх, уг эрсдэлийн үнэлгээнд суурилан эрсдэлийг бууруулах бодлого, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг 2020 оны 01 дүгээр сараас хийж гүйцэтгэсэн. Энэ хүрээнд Сангийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 20 дугаар тушаалаар Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийх үндсэн ажлын хэсгийг байгуулснаас гадна Сангийн сайдын 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 90 дүгээр тушаалаар зохицуулалттай салбар тус бүрийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх 10 модулийн дэд ажлын хэсгийг байгуулж ажиллав. Үүнд:


- Модуль 1. Мөнгө угаах аюул заналхийллийг үнэлэх дэд ажлын хэсэг
- Модуль 2. Үндэсний эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг
- Модуль 3. Банкны салбарын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг

- Модуль 4. Үнэт цаасны салбарын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг
- Модуль 5. Даатгалын салбарын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг
- Модуль 6. Бусад санхүүгийн байгууллагын салбарын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг
- Модуль 7. Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн салбарын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг
- Модуль 8. Терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх дэд ажлын хэсэг
- Модуль 9. Санхүүгийн хүртээмжтэй бүтээгдэхүүний эрсдэлийг үнэлэх дэд ажлын хэсэг
- Модуль 10. Ашгийн бус байгууллагын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг

Дээрх дэд ажлын хэсгүүдэд төрийн байгууллагууд болон холбогдох бүхий л салбарын хувийн хэвшлийн нийт 52 байгууллагын 128 төлөөлөгчид орж ажилласан бөгөөд Дэлхийн банкнаас нийт ажлын хэсгийн гишүүд болон дэд ажлын хэсэг тус бүрт эрсдэлийн үнэлгээ хийх цахим сургалтуудыг зохион байгуулсан.

Ажлын хэсгийн зүгээс Дэлхийн банкны аргачлалд үндэслэн дараах бүдүүвч зурагт үзүүлсний дагуу Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэв.

Зураг 1. Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийх бүдүүвч зураглал



Эх сурвалж: Дэлхийн банкны гарын авлага

Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийснээр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх нөөц бололцоог зөв хуваарилах, болзошгүй эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх боломж нөхцөл бүрдэх юм. Мөн түүнчлэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны бодит үр дүнг дээшлүүлэх, шууд хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийг сайжруулах, тогтолцоог чанаржуулах ач холбогдолтой.


Зураг 2. Үндэсний эрсдэлийн үнэлгээний ач холбогдол



Эх сурвалж: Дэлхийн банкны танилцуулга

Иймд ажлын хэсгийн зүгээс Дэлхийн банкны аргачлал болон ФАТФ-ын гарын авлагад зөвлөснөөр дараах бүдүүвч зурагт үзүүлсэн үе шатуудын дагуу холбогдох мэдээллийг цуглуулсан, дүн шинжилгээ хийж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг тодорхойлж ажиллав. Энэ хүрээнд юуны түрүүнд, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг аюул заналхийлэл болон эмзэг байдалд тулгуурлан тодорхойлж, дараагийн үе шатанд дүн шинжилгээг хийсэн.

Зураг 3. Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийх үе шатууд



Эх сурвалж: ФАТФ-ын Үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх гарын авлага

Санхүүгийн мэдээллийн албаны зүгээс долоо хоног бүр ажлын явцыг хэлэлцэх, цаашид хийгдэх ажлуудыг тодорхойлох уулзалтуудыг зохион

байгуулсан. Эдгээр уулзалтуудын үр дүнд 2020 онд салбар тус бүрийн эрсдэлийн үнэлгээг хийх хэлэлцүүлгүүдийг бүрэн зохион байгуулав. Улмаар салбар тус бүрийн эрсдэлийн үнэлгээний үр дүн, дүгнэлтүүдийг урьдчилсан байдлаар боловсруулсан бөгөөд ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтад бэлтгэх зорилгоор нэгдсэн хэлэлцүүлгийг Санхүүгийн мэдээллийн албанаас бүх ажлын хэсгийн гишүүн байгууллагуудтай хамтран 2020 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулав.

Санхүүгийн мэдээллийн алба нь Үндэсний эрсдэлийн үнэлгээний тайланг эцэслэн боловсруулах ажлын хүрээнд 2020 оны 10 дугаар сарын 26-30-ны өдрүүдэд нийт 5 өдөр 10 дэд ажлын хэсэг тус бүрийн хийсэн үнэлгээний талаарх хэлэлцүүлгийг Хууль зүй, дотоод хэргийн яам болон Авлигатай тэмцэх газар дээр амжилттай зохион байгуулав. Тус хэлэлцүүлэгт холбогдох яамд, төрийн байгууллагууд, шүүх, прокурор, хууль сахиулах байгууллагууд, судлаач эрдэмтэд, мэргэжлийн холбоод болон хувийн хэвшлийн нийт 250 гаруй төлөөлөл оролцон нийт 10 модулийн тайланг хэлэлцэн, санал дэвшүүлж, сайжруулах талаар үзэл бодлоо илэрхийллээ.

Зураг 4. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээний хэлэлцүүлэг /2020.10.26-30/



Эх сурвалж: Монголбанк, СМА

Дэд ажлын хэсгүүд эдгээр хэлэлцүүлгийн үеэр дэвшүүлсэн оновчтой санал, зөвлөмжүүдийг өөрсдийн модулийн тайландаа тусгасан. Мөн Эрсдэлийн үнэлгээний тайлангийн төслийг Дэлхийн банкны санал зөвлөмжид тулгуурлан холбогдох сайжруулалтыг хийж, эцэслэн гаргахаар ажиллаж байна.

Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний 2 дахь тайлангийн үр дүнд үндэслэн “Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дунд хугацааны Үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний зөвлөл болон Хамтын ажиллагааны зөвлөлөөр хэлэлцүүлж, батлуулахаар төлөвлөж байна. Энэхүү Үндэсний хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, ФАТФ-ын техникийн хэрэгжилт болон шууд хэрэгжилтийн үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх асуудлуудыг дэлгэрэнгүй тусгах бөгөөд Санхүүгийн мэдээллийн алба, Монголбанк, Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, хууль сахиулах байгууллагууд болон бусад холбогдох байгууллагууд хамтран хэрэгжүүлж ажиллах болно.

Үндэсний хөтөлбөрөөр дамжуулан Улсын Их Хурлын 2020 оны 52 тоот тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 оны хооронд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Улсын Их Хурлын 2020 оны 23 тоот тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын Их Хурлын 2020 оны 24 тоот тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ач холбогдолтой юм.


МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН

Монгол Улс зах зээлийн нийгэм, эдийн засгийн харилцаанд шилжсэн эхний жилийн жигнэсэн дундаж хүү 300 хувьд хүрч байв. Бодлогын хүүг 2007 онд анх нэвтрүүлж, нийт актив сүүлийн 16 жилийн дотор 36.6 тэрэгн


ДНБ-ий өсөлт. (1990-2020)




Зээлийн жигнэсэн дундаж хүү



Жилийн инфляц




Банкны актив



МОНГОЛЫН ЗАСАГ 30 ЖИЛД

Төгрөг/ам.долларын ханш, Сарын дундаж
илүүдэд ДНБ 9.2 хувиар агшиж, инфляц жилийн 268 хувь хүртэл өсч, зээлийн
ж байсан бол 2020 оны эцэст 6.0 хувь буюу түүхэн доод түвшинд хүрэв. Банкны
их наяд төгрөгт хүрч, 36 дахин өссөн байна.



Эх сурвалж: Монголбанк

ХОЁР ШАТЛАЛТ

БАНКНЫ СИСТЕМИЙН ХӨГЖИЛ



Голомт банкны
Ерөнхийлөгч
Г.ГАНБОЛД

Зах зээлд шилжих үед манай улсын хувийн хэвшил болон хувийн банкны хөгжил зэрэгцээд л явсан. Уг нь энгийнээр бодоход эхлээд банк нь бий болоод, санхүүгийн эх үүсвэр, зуучлал бий болсны дараа хувийн хэвшил явчихаар санагдаад байгаа юм. Гэтэл 1990 оноос хойш арилжааны банк болон хувийн хэвшил яг л нэг гараанаас хамтдаа хөгжөөд явчихсан. Нэг сонин жишээ дурдахад, Голомт банк анх байгуулагдахад яг замын цаана нь “Мобиком” байгуулагдаж байсан. Мобикомын анхны үйлчилгээ, манай анхны данс нээх хоёр зэрэгцээд л хийгдэж байлаа.

1990-ээд онд бид зах зээлд шилжихэд жилийн инфляц 400 хувьтай байсан. Зээлийн хүү сарын 20 хувь байсан. Харин өнөөдөр зээлийн хүүгийн дундаж 14-15 хувь, инфляц 5.6 хувь байна. Тэгэхээр 30 жилийн хугацааны санхүүгийн гол үзүүлэлт нь төгрөг тогтворжиж, эх үүсвэр хямдарсан байгаа.

Голомт банкны хувьд эхлээд бүх төрлийн үйлчилгээ явуулж ирсэн бол сүүл рүүгээ корпорейт секторт төвлөрч ажиллах болсон. Өнөөдөр манай эх үүсвэрийн багцын дийлэнх нь корпорейт дээр төвлөрч байна. Жишээлбэл, олон улсын томоохон төслүүд, “Оюу Толгой” гэх мэт. Мөн Монголын томоохон төрийн өмчийн компаниуд буюу “Эрдэнэс Тавантолгой”, “Иргэний нисэхийн ерөнхий газар”, “Улаанбаатар төмөр зам” ХНХ гэх зэргээр дурдаж болно. Мэдээж эдгээрээс гадна хувийн хэвшлийн томоохон корпорейт харилцагчдад бид санхүүгийн иж бүрэн үйлчилгээг үзүүлж, хөгжүүлээд явж байна. Жишээлбэл, алтны санхүүжилтийн 60-70 хувийг Голомт банк дангаараа авч явж байгаа. Энэ тал дээр Монголбанкны хэд хэдэн удаагийн бодлогын дэмжлэг чухал ач холбогдолтой байсан. Алтны зах зээл ид өсч, үнэ тогтвортой байгаа үед бид алтны уурхайнуудаа аль болохоор хямд, урт хугацаатай эх үүсвэрээр дэмжих ёстой.



**ХААН банкны
Гүйцэтгэх захирал
Г.МӨНХТУЯА**

Энэ 30 жилийн хугацаанд манай банкны хувьд унаж, боссон, сорилттой олон үеийг туулж ирлээ. 1991 онд байгуулагдсанаасаа хойш 1998 онд Бүрэн Эрхт Төлөөлөгч томилогдож байсан, 2000 онд Засгийн газраас дахин санхүүжилт хийгдэж, гадны хөрөнгө оруулалт, менежментийн хувьчлал хийгдсэн. Ингээд өмч хувьчлалд бэлдэж эхэлснээр 2003 онд өмч хувьчлал хийгдэж, одоогийн манай хөрөнгө оруулагч нар банкныг худалдаж авсан байгаа. Тэрнээс хойш бид унаж явсан банкныг сэргээх талаар эрчимтэй ажиллаж ирлээ. Би 2000 оноос хойш ХААН банкиндаа ажиллаж байна. 21 жилийн хугацаанд бид санхүүгийн хувьд хамгийн тогтвортой байх ёстой, хатуу чанд, сахилга баттай байж, олон улсын стандартыг мөрдөх ёстой, Монгол Улсад үйлчилж байгаа бүх хууль тогтоомжуудыг мөрдөж байж, санхүүгийн хувьд амжилттай, тогтвортой байдаг гэсэн байр суурьтай байна.

Зөвхөн хууль тогтоомжийг мөрдөөд зогсохгүй энэ бол ёс зүйн асуудал байгаа. Ялангуяа банкны бизнес бол хүний хүчин зүйл дээр тулгуурлаж хөгждөг бизнес. Тэгэхээр байгууллага, ажилтнууд, удирдлагууд, бүх түвшиндөө бизнесийн ёс зүйтэй байх ёстой гэдэг шаардлага чухлаар тавигддаг. Манай банкны хувьд ёс зүйн дүрэмтэй, ёс зүйн дүрмийг биелүүлэхгүй байвал маш хатуу хариуцлага яригддаг. Үүний хүрээнд харилцагчийн мэдээллийн нууцыг хадгалах тал дээр нэлээд анхаарал хандуулдаг.

ХААН банкны хувьд иргэдийн банкны зах зээл дээр дийлэнх хувийг нь эзэлдэг. Манай банкны нийт активын бараг 80 орчим хувь нь иргэдийн банкинд дээр төвлөрсөн байгаа. Монгол Улсын 2.5 сая иргэн Хаан банкинд данстай байна. Энэ нь Монголын хүн амын 75 орчим хувь гэсэн үг. Тэгэхээр бид тэдэнд тохирсон түргэн шуурхай, орчин үеийн үйлчилгээ үзүүлэхийг зорьж байна. Сүүлийн хэдэн жилийн хугацаанд бидний анхаарч хийж байгаа зүйл бол банкныг дижитал болгох, гар утаснаасаа банкны үйлчилгээ авах боломжийг харилцагчдадаа нээлттэй болгох чиглэл рүү нэлээд хөрөнгө оруулалт хийж байна. Энэ утгаараа 5 жилийн өмнөхтэй харьцуулахад манай нийт гүйлгээний 50 хувь нь цахим банк, 50 хувь нь банкинд дээр ирж хийдэг байсан бол өнөөдөр 2021 оны дөрөвдүгээр сарын байдлаар өдөрт 60 орчим сая ширхэг санхүүгийн гүйлгээ хийж байна. Эдгээрийн 98 хувь нь цахим банкаар хийгдэж, манай 550 орчим салбар нэгж дээр нийт төлбөр тооцооны 2-3 хувь нь л хийгдэж байна.



**Худалдаа Хөгжлийн
Банкны Гүйцэтгэх
захирал
О.ОРХОН**

Анх банкны систем үүсч хөгжихөд бидэнд туршлага бага байсан. Хаалттай нийгэмд байсан учраас зах зээлийн өрсөлдөөн, зарчим гэж юу байдгийг сайн ойлголгүйгээр шууд л зах зээлийн эдийн засаг руу орчихсон. Дээрээс нь тухайн үед маш өндөр түвшний инфляцтай, түүийг дагасан маш өндөр хадгаламж болон зээлийн хүүтэй орчинд үйл ажиллагаа явуулж байсан. Тэгэхээр 1990-ээд оны эхний хагас жил Монголын банкны салбарын хувьд хүндхэн жилүүд байсан. Ингээд 1990-ээд оны дунд үеэс олон улсын байгууллагуудтай хамтарч, банкны салбарыг чадавхжуулах, хяналт шалгалтын олон улсын стандартыг нэвтрүүлэх гээд олон чиглэлээр ажиллаж ирлээ. Хамгийн сүүлд ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд активын чанарын үнэлгээг хийх тал дээр бид хамтран ажиллалаа. Өөрөөр хэлбэл, Монголын банкууд хэр зэрэг эрүүл байна вэ, хэр зэрэг олон улсын стандартыг хангаж байна вэ гэдгээ хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлсэн. Тухайн үед бид олон улсын өндөр түвшний, Монгол Улсад өмнө нь хэзээ ч байгаагүй, хэт өндөр стандартаар шалгаж байна гэж эсэргүүцэж байсан. Яагаад гэвэл дотооддоо бага, дунд ангийн боловсрол олгочихоод, олон улсын өндөр түвшний их сургуулийн хэмжээний шалгалт авч болохгүй гэдэг байдлаар хандаж байсан. Гэхдээ үүнд мэдээж сайн тал бий. Нэг талаас Монголын арилжааны банкууд үүнийг даваад гарсан гэхээр бид тийм ч муу боловсролтой байгаагүй юм байна гэдгийг нотолж харуулсан. Хоёрдугаарт, цаашид бид томорьё гэж байгаа бол ямар стандарттай, ямар түвшинд өөрсдийгөө бэлдэх ёстой вэ, юу дутуу байна вэ гэдгээ эндээс харсан.

Тэгэхээр цаашдаа бид эрсдэлийн удирдлагаа улам сайжруулж, олон улсын түвшинд хүргэхийн сацуу том зургаар нь харж байх ёстой юм байна. Зөвхөн нэг харилцагч, нэг зээлийн бүтээгдэхүүн бус банкаа нийтэд нь, бүр цаашилбал, системийн хэмжээнд, Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын түвшинд бүхэлд нь эрсдэлээ харж, үнэлж байх ёстой гэдгийг ойлгосон. Энэ утгаараа Монголын банк, санхүүгийн салбарт эрх зүйн шинэчлэлийн алхмууд маш эрчимтэй хийгдлээ. Томоохон өөрчлөлтүүд энэ салбарт гарах гэж байна.




**Монголын Банкны
Холбооны Гүйцэтгэх
захирал
Л.АМАР**

Дэлхий дээр бизнесийг дэмждэг санхүүгийн хоёр л гол эх үүсвэр бий. Нэг нь хөрөнгийн бирж, нөгөө нь банкны систем. Гэтэл өнөөдөр Монголын хувьд нэг тал нь хөгжихгүй болохоор “доголон морь” шиг л байгаа юм. Тэгэхээр банкны сектор өнөөдрийг хүртэл “доголоод” л, өндөр хүүтэйгээрээ дуудуулаад сүүлийн 30 жилийн Монголын бүхий л үйл ажиллагааг санхүүжүүлж ирлээ. Зөвхөн бизнес гэлтгүй төрийн тэтгэвэр, халамж олгох гээд бүхий л үйлчилгээг дамжуулах болон Засгийн газрын хөтөлбөрүүдийг хүртэл санхүүжүүлээд явж байна. Тийм учраас өнөөгийн түвшинд би Монголын банкны салбарыг дэлхийн түвшинд хүрсэн гэж харж байгаа. Ялангуяа үйлчилгээ талаас нь яривал Монголын банкууд шиг хэрэглэгчдэд хүрч чадсан банкны салбартай улс орон маш цөөхөн байдаг. Технологийн хөгжил сайтай Зүүн Өмнөд Азийн орнууд харьцангуй гайгүй. Гэтэл хуучны буюу уламжлалт, олон зуун жил хөгжсөн банкны системтэй барууны орнуудад банкны салбарын зарим үзүүлэлтүүд нь манайхаас хоцорчихсон байгаа.

Гэхдээ цаашид хийгдэх ёстой ажлууд мэдээж олон бий. Банкны салбарын хувьд иргэдэд илүү нээлттэй болох, хувьцаа эзэмшигчдийн төвлөрлийг бууруулах, хувьцаат компанийн хэлбэрт шилжиж, засаглалын хувьд илүү өндөр түвшинд хүрэх шаардлага бий. Банкны салбар засаглалын хувьд бусад салбаруудтай харьцуулахад хамаагүй өндөр түвшинд байгаа. Гэхдээ хөгжлийн түүчээн хувьд дараагийн шатанд гарах шаардлагатай. Банкны тухай хууль шинэчлэгдсэн. Ингэснээр банкууд олон нийтийн банк болж хувирах ажил эхэлсэн. Энэ бол хөгжлийн бас нэг үе шат. Финтекийн хувьд ч бас Монголын банкууд хөгжлийн шинэ шатанд гарч, банкны үйлчилгээг иргэдийн гарт хэдийнэ атгуулчихсан байна. Үнэндээ Монголын банкууд анх АТМ-ээс картгүйгээр мөнгө авах технологийг нэвтрүүлж байхад дэлхийд тийм үйлчилгээ бараг л байдаггүй байлаа шүү дээ. Тэгэхээр хөгжлийн дараагийн шатанд гарсан энэ зүйлүүдээ олон улсын түвшинд гаргах, борлуулах боломж банкны салбарт нээлттэй байна. Өөрөөр хэлбэл, манай улсын хувьд экспортын томоохон орлогыг нэмэгдүүлж болох нэг томоохон салбар нь банкны салбар, түүний бий болгосон финтекийн бүтээгдэхүүн болохоор байна.

ХОЁР ШАТЛАЛТ БАНКНЫ ТОГТОЛЦООНЫ ТҮҮХЭН ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ



ТӨВ БАНК, АРИЛЖААНЫ БАНКНЫ ЯЛГАА

Улс төр, нийгэм, эдийн засгийн эрс шинэтгэл хийсэн 1990 онд "Аж ахуйн банк байгуулах болон түүний үйл ажиллагааны нийтлэг дүрэм", 1991 онд "Банкны тухай хууль" батлагдсанаар Монгол Улсад 2 шатлалт банкны тогтолцооны хөрс суурийг тавьсан байдаг. Сүүлийн 20 жил Монгол Улсын санхүүгийн захыг үндсэндээ банкны систем тодорхойлсоор ирсэн бөгөөд өнөөдрийн байдлаар арилжааны 12 банк үйл ажиллагаа явуулж байна. Харин банкны хадгаламж, зээлийн захууд нь ихээхэн сегментчлэгдсэн байдаг нь Монгол Улсын банкны салбарын онцлог юм. Иймд Төв банк болон арилжааны банкны хэрэгжүүлж буй үүрэг, зорилго нь өөр хоорондоо ихээхэн ялгаатай бөгөөд тэдгээрийг товч дурдвал дараах байдалтай байна. Үүнд:



АРИЛЖААНЫ БАНК НЬ...

- Үйл ажиллагаа нь "Банкны тухай" хуулиар зохицуулагддаг.
- 12 банкнаас 11 нь хувийн, нэг нь төрийн эзэмшилд байдаг.
- Ашгийн төлөө санхүүгийн байгууллага юм.
- Мөнгөн тэмдэгт хэвлэж гүйлгээнд гаргах эрхгүй, мөнгөний бодлого боловсруулахгүй.
- Иргэд, аж ахуйн нэгжээс харилцах, хадгаламж татан төвлөрүүлдэг.
- Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад богино, дунд хугацааны зээл олгодог.
- Банк хоорондын төлбөр тооцоог зохицуулах эрхгүй.
- Үйл ажиллагаагаа хувь (хувьцаа) эзэмшигчдийн өмнө тайлагнана.



ТӨВ БАНК БУЮУ МОНГОЛБАНК НЬ...

- Үйл ажиллагаа нь "Төв банк /Монголбанк/-ны тухай хуулиар зохицуулагддаг.
- Төрөөс үүсгэн байгуулсан хуулийн этгээд юм.
- Ашгийн бус байгууллага юм.
- Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргадаг, мөнгөний бодлогыг боловсруулж хэрэгжүүлнэ.
- Харилцах дансны эзэмшигчид нь банкууд, Төрийн сангийн нэгдсэн дансын эзэмшигч нь Засгийн газар байдаг.
- Шаардлагатай тохиолдолд Монголбанкнаас арилжааны банкууд болон Засгийн газарт зээл олгодог.
- Банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулна.
- Үйл ажиллагаагаа УИХ-д тайлагнадаг.

